**Агуулга**


**Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал ..........................3**

**I. Нийгмийн үзүүлэлт ........................................................ 6**

1. Бүртгэлтэй ажилгүй иргэн ................................................ 6
2. Дундаж цалин ...................................................... 7
3. Нийгмийн даатгал, халамж ........................................ 8
4. Эрүүл мэнд .......................................................... 10
5. Гэмт хэрэг ..............................................................11
6. "Тогтвортой амьжиргаа-II" төслийн үр дүн ............................13

**II. Макро эдийн засгийн үзүүлэлт ........................................ 14**

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн...............................................14
2. Үнэ ..........................................................................15
   - орон сууцны үнийн индекс
3. Мөнгө, зээл, үнэт цаас ................................................20
4. Улсын нэгдсэн төсөв.......................................................24
5. Гадаад худалдаа .........................................................25

**III. Үйлдвэрлэл, үйлчилгээ ................................................... 28**

1. Мал аж ахуй ............................................................ 28
2. Аж үйлдвэр ............................................................ 28
3. Тээвэр ...................................................................... 30
4. Нийтийн хоол, зочид буудал ........................................ 31

**IV. Бусад ................................................................... 32**

1. Цаг уур, агаарын бохирдолт ........................................ 32

**V. Хавсралт ......................................................................... 34**

**VI. Гадаад худалдааны төлөв байдал .................................. 47**

**VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм ............... 54**

**Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:**

...  **мэдээлэл байхгүй**
0.0  **маш бага тоо**
-  **гүйцэтгэл байхгүй.**

# Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал (2012 оны 1 дүгээр сарын байдлаар)

## I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 6015 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 852 эх буюу 16.5 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 6033 болж, 843 хүүхэд буюу 16.2 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард нэг хүртэлх насандаа 105 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хүүхэд буюу 11.7 хувь, 1-5 хүртэлх насны 21 хүүхэд эндэж, 5 хүүхэд буюу 31.3 хувиар нэмэгджээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 1 дүгээр сарын эцэст 58.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.8 мян.хүнээр буюу 51.7 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалд 2012 оны 1 дүгээр сард 115.6 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 68.8 мянга буюу 59.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 46.8 мянга буюу 40.5 хувь нь төсөвт байгууллагынх байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны 1 дүгээр сард 53.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 мян.хүн буюу 4.8 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 131.9 сая төг буюу 4.8 хувиар нэмэгджээ.

“Хүний хөгжил” сангаас 2012 оны 1 дүгээр сард 32.9 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.6 сая иргэнд олгожээ.

Халдварт өвчнөөр 2012 оны 1 дүгээр сард 3815 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 765 хүн буюу 25.1 хувиар нэмэгдэхэд тэмбүү өвчнөөр өвчлөгчдийн тоо 102 хүн буюу 39.4 хувь, трихомониаз өвчнөөр 69 хүн буюу 24.9 хувь, салхин цэцгээр 69 хүн буюу 24.8 хувь, сүрьеэгээр 34 хүн буюу 12.6 хувь, гонококкт халдвараар 39 хүн буюу 10.6 хувь, цусан суулгаар 3 хүн буюу 2.7 хувь, вирүст хепатитээр 101 хүн буюу 7.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 2265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 413 хэргээр буюу 22.3 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (255), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (110) тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (20) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2012 оны 1 дүгээр сард 707 хүн гэмтэж, 199 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 61 буюу 9.4 хувиар, нас барсан хүний тоо 20 буюу 11.2 хувиар өссөн байна.

## II.Макро эдийн засгийн үзүүлэлт

ДНБ оны үнээр 2011 оны эхний улиралд өмнөх оны мөн үеийнхээс 19.8 хувь, эхний хагас жилд 29.4 хувь, эхний 3 улиралд 31.7 хувь, жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 28.7 хувиар өсч, 10829.7 тэрбум төгрөгт хүрлээ.

ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 оны эхний улиралд өмнөх оны мөн үеийнхээс 9.8 хувь, эхний хагас жилд 14.0 хувь, эхний 3 улиралд 16.5 хувь, харин жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4881.4 тэрбум төгрөгт хүрч, 17.3 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 4.9 хувь, тээврийн бүлгийнх 5.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2012 оны 1 дүгээр сарын эцэст 6150.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 262.1 тэрбум төг буюу 4.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1344.7 тэрбум төг буюу 28.0 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 1 дүгээр сарын эцэст 657.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 56.4 тэрбум төг буюу 7.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 91.3 тэрбум төг буюу 16.1 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 5649.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 7.8 тэрбум төг буюу 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2208.7

тэрбум төг буюу 64.2 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 73.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төг буюу 0.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 29.2 тэрбум төг буюу 28.3 хувиар буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 328.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.0 тэрбум төг буюу 0.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 33.5 тэрбум төг буюу 9.3 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа 2012 оны 1 дүгээр сард 22 өдөр явагдаж, 4.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 4.8 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 325.8 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 260.0 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 65.8 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн урсгал орлого 2012 оны 1 дүгээр сард 324.3 тэрбум төг, урсгал зардал 257.2 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 67.2 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 93.2 тэрбум төг буюу 46.3 хувиар нэмэгдэхэд хэдийгээр дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 18.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурсан хэдий ч гадаад худалдааны татварын орлого 51.8 тэрбум төг буюу 3.8 дахин, бусад татварын орлого 45.1 тэрбум төг буюу 3.2 дахин, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 17.1 тэрбум төг буюу 72.8 хувь, хүн амын орлогын албан татварын орлого 6.5 тэрбум төг буюу 50.5 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 3.9 тэрбум төг буюу 17.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 15.3 тэрбум төг буюу 2.0 дахин нэмэгдэхэд навигацын орлого 2.2 тэрбум төг, газрын тосны орлого 0.6 тэрбум төг буюу 43.1 хувиар буурсан хэдий ч төсөвт газрын өөрийн орлого 8.5 тэрбум төг буюу 2.1 дахин, бусад нэр заагдаагүй орлого 6.2 тэрбум төг буюу 5.4 дахин, хүү, торгуулийн орлого 3.2 тэрбум төг буюу 3.0 дахин, хувьцааны ногдол ашгийн орлого 0.2 тэрбум төг буюу 606.5 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 260.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 13.5 тэрбум төг буюу 5.5 хувиар өсөхөд эргэж төлөгдөх цэвэр зээл 9.5 тэрбум төг, хөрөнгийн зардал 6.1 тэрбум төг буюу 45.8 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 19.3 тэрбум төг буюу 15.5 хувь, бараа, үйлчилгээний зардал 8.3 тэрбум төг буюу 8.8 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 1.5 тэрбум төг буюу 15.3 хувиар өссөн нь шалтгаалжээ.

Хөрөнгийн зардалд 2012 оны 1 дүгээр сард 7.3 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 6.1 тэрбум төг буюу 45.8 хувиар буурчээ. Үүнд гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 5.0 тэрбум төг, дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 2.3 тэрбум төг байна.

Манай улс 2012 оны 1 дүгээр сард дэлхийн 94 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 735.2 сая ам.долл, үүнээс экспорт 240.3 сая ам.долл, импорт 494.9 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны 1 дүгээр сард 139.6 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2012 оны 1 дүгээр сард 254.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 115.0 сая ам.долл буюу 82.4 хувиар өсчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 178.4 сая ам.долл буюу 32.0 хувь, үүний дотор импортын хэмжээ 146.7 сая ам.доллараар буюу 42.1 хувь, экспортын хэмжээ 31.7 сая ам.долл буюу 15.2 хувиар өсчээ.

Экспортын 97.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

## III.Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Том малын зүй бус хорогдол 2012 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 22.8 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 41.7 мян. толгой буюу 64.6 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр авч үзвэл адуу 1.5 мянга, үхэр 2.2 мянга, тэмээ 49, хонь 9.2 мянга, ямаа 9.8 мянга байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны 1 дүгээр сард 154.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 тэрбум төг буюу 5.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, металл агуулгаараа, хайлуур жоншны баяжмал, молибдений баяжмал, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.6-74.2 хувь, нарийн боов, хивс, шар айраг, шохой, талх, амтат ус, ундаа, цахилгааны утас, самнасан ноолуур, жүүс, бетон дэр, гоймон, шавардлагын зуурмаг, бетон зуурмаг, цемент, малын мах, шахмал түлш зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл  5.0 хувиас 10.8 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр 2012 оны 1 дүгээр сард 1733.8 мян.т ачаа, давхардсан тоогоор 293.7 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 388.7 мян.т буюу 28.9 хувь, зорчигчдын тоо 0.7 мян.хүн буюу 0.3 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны 1 дүгээр сард 32.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.0 тэрбум төг буюу 31.9 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2012 оны 1 дүгээр сард 302.3 т ачаа, давхардсан тоогоор 46.2 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 173.7 т буюу 2.3 дахин, зорчигчдын тоо 9.7 мян.хүн буюу 26.5 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны 1 дүгээр сард 11.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 тэрбум төг буюу 28.2 хувиар өсчээ.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 1 дүгээр сард Завхан аймгийн Баянтэс суманд (3.8 мм) орсон байна. Энэ оны 1 дүгээр сард Баянхонгор аймгийн Баянцагаан суманд хамгийн их температур 0.0 хэм, Завхан аймгийн Тосонцэнгэл, Отгон суманд хамгийн бага температур -50.0 хэм байлаа. Салхины хурд Өмнөговь аймгийн Булган суманд 20 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотын Хархорин захын орчимд 31 удаа, 13-р хороолол, Офицеруудын ордон орчимд  тус бүр 26 удаа, 32-ын тойрог орчимд 22 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Хархорин захын орчимд 31 удаа, Офицеруудын ордон, 32-ын тойрог орчимд тус бүр 27 удаа, Баруун дөрвөн зам орчимд 25 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа, Мишээл экспо төвийн орчимд 9 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин захын орчимд 30 удаа, 32-ын тойрог орчимд 23 удаа, 13-р хороолол орчимд 20 удаа,  Баруун дөрвөн зам орчимд 19 удаа,  2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн зам орчимд 21 удаа, угаарын хий 32-ын тойрог орчимд 3 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Аюулт үзэгдэл, осол 2012 оны 1 дүгээр сард 343 удаа гарсны улмаас 13 хүн амь насаа алдаж, 0.4 мян.толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Энэ оны 1 дүгээр сард объектын түймэр 328 удаа, бичил уурхай, нурангины осол 3 удаа,  гол, нуурын усанд унасан осол 2 удаа, мал, тэжээвэр амьтны галзуу өвчин 1 удаа, бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2012 оны 1 дүгээр сард 0.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна

## I.1.1. Бүртгэлтэй ажилгүй иргэн*

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 1 дүгээр сарын эцэст 58.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.8 мян.хүнээр буюу 51.7 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 25.2 мянга буюу 43.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 9.3 пунктээр буурчээ. Аймаг, нийслэлийн ХХҮХ-т 2012 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар ажилгүй 3.6 мян.иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 1.5 мян.иргэн ажилд зуучлагдан орж, 689 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ. (Зураг I.1)

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.7 хувь нь магистр, доктор, 20.8 хувь нь дипломын болон бакалаврын, 6.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 45.4 хувь нь бүрэн дунд, 16.1 хувь нь суурь, 2.9 хувь нь бага, 0.8 хувь нь боловсролгүй иргэд байна (Зураг I.2). Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 33.4 мянга буюу 57.4 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Архангай, Дундговь, Говьсүмбэр,Төв, Өмнөговь, Орхон, Хэнтий, Дорнод, Баян-Өлгий, Дорноговь,Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул аймагт улсын дунджаас 0.1-24.4 пунктээр их байна.

Зураг-I.1

**ХХҮХ-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн 1 дүгээр сарын эцсийн байдлаар**




Зураг-I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2012 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар, хувиар**




## I.1.2. Ажлын шинэ байр *

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэдээгээр ажлын шинэ байр 2012 оны 1 дүгээр сард 339 бий болжээ. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 188 нь буюу 55.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 6.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 7.7 хувь нь байр сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны, 8.3 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 12.1 хувь нь уул уурхай олборлолтын, 12.7 хувь нь боловсролын, 15.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 17.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний, 19.7 хувь нь бусад салбарт ногдож байна (Зураг I.3).

Зураг-I.3

**Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2012 оны 1 дүгээр сард, хувиар**




** Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр*

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг насны ангиллаар авч үзэхэд 46 буюу 13.6 хувь нь 15-24 , 123 буюу 36.3 хувь нь 25-34, 107 буюу 31.6 хувь нь 35-44, 61 буюу 18.0 хувь нь 45-59, 2 буюу 0.5 хувь нь 60, түүнээс дээш насны хүмүүс байна.(Зураг I.4).

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 0.3 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 0.6 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 1.8 хувь нь менежер, 2.4 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 5.9 хувь нь хөдөө аж ахуй, загас агнуурын ажилтан, 9.4 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 12.7 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний ажилтан, 16.8 хувь нь мэргэжилтэн, 20.6 хувь нь энгийн ажил мэргэжил, 29.5 хувь нь худалдаа, үйлчилгээний мэргэжилтэй хүмүүс байна.

Зураг-I.4

**Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, насны бүлгээр, 2012 оны 1 дүгээр сард, хувиар**




## I.2. Дундаж цалин

Ажиллагчдын дундаж цалингийн 2011 оны 4 дүгээр улирлын түүвэр судалгаанд нийслэлийн 195, аймаг, орон нутгийн 822, нийт 1017 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдлаа. Судалгаанд 156.8 мянган ажиллагчид хамрагдсаны 80.9 мянга буюу 51.6 хувь нь эмэгтэйчүүд байв.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2011 оны 4 дүгээр улиралд 450.3 мян. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 70.9 мян. төг буюу 18.7 хувиар нэмэгджээ (Зураг I.5).

Ажиллагчдын сарын дундаж цалин 2011 онд 424.2 мян.төг болж, өмнөх оныхоос 82.7 мян.төг буюу 24.1 хувиар нэмэгдлээ.

Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин 2011 оны 4 дүгээр улиралд 502.1 мян.төг болж, эмэгтэйчүүдийнхээс 100.4 мян.төг буюу 25.0 хувиар илүү байна (Зураг I.5).

Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерээр ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин 823.4 мян.төг буюу хамгийн их байхад бичиг хэргийн туслах ажилтнаар ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн цалин 309.2 мян.төг буюу хамгийн бага байна. Мөн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерeeр ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн сарын дундаж цалин 671.6 мян.төг буюу хамгийн их байхад ХАА, загасны аж ахуйн мэргэшсэн ажилтнаар ажиллаж буй эмэгтэйчүүдийн цалин 262.7 мян. төг буюу хамгийн бага байна (Зураг.I.6).

Зураг-I.5

**Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, ажил мэргэжлийн ангиллаар, 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар**




Зураг-I.6

**Ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар**



Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, барилгын салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 2011 оны 4 дүгээр улиралд 455.4 мян.төг, тээвэр, холбоо, агуулахын аж ахуйн салбарынх 509.8 мян.төг, уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарынх 752.4 мян.төг, санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны салбарынх 992.0 мян.төг болж, улсын дунджаас 5.1-541.7 мянган төгрөгөөр их, харин боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж, эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарынх 17.4-97.7 мян.төг, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбар, зочид буудал, зоогийн газар, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа болон хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарынх 117.1-256.6 мянган төгрөгөөр бага байна.

Зураг-I.7

**Ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар**




*ХК - Хувьцаат компани*
*ТӨҮГ - Төрийн өмчит үйлдвэрийн газар*
*ОНӨҮГ - Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар*
*ХХК - Хязгаарлагдмал хариуцлагатай компани*
*ББН - Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл*
*ЗБН - Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл*

Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд, хязгаарлагдмал хариуцлагатай компани болон төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдын сарын дундаж цалин 2011 оны 4 дүгээр улиралд улсын дунджаас 63.4-65.4 мянган төгрөгөөр их, харин хувьцаат компани, төсөвт байгууллагынх 11.3-43.8 мян.төг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөлд ажиллагчдын цалин 82.9-161.2 мян.төг, төрийн бус байгууллага болон хоршооных 185.8-229.7 мянган төгрөгөөр бага байна (Зураг I.7). Мөн төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин 2011 оны 4 дугаар улиралд 406.5 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.9 мян.төг буюу 5.7 хувиар нэмэгджээ.

## I.3 Нийгмийн эмзэг бүлэг

### Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны 1 дүгээр сард 51.0 тэрбум төг, зарлага 49.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 2.0 тэрбум төг буюу 3.8 хувь, зарлага 12.2 тэрбум төг буюу 19.8 хувиар буурлаа.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 2.0 тэрбум төгрөгөөр буурахад, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 2.2 тэрбум төг буюу 2.4 дахин, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 4.4 тэрбум төг буюу 90.7 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 452.9 сая төг буюу 40.1 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 190.6 сая төг буюу 15.8 хувиар өссөн хэдий ч, тэтгэврийн даатгалын сангийн орлого 9.2 тэрбум төг буюу 20.7 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 12.2 тэрбум төгрөгөөр буурахад, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 587.3 сая.төг буюу 39.2 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 51.4 сая төг буюу 0.9 хувиар өссөн хэдий ч, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 360.1 сая төг буюу 42.7 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 12.1 тэрбум төг буюу 23.6 хувиар, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 345.1 сая төг буюу 17.5 хувиар буурсан нь нөлөөлөв.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 37.8 тэрбум төг болсны 72.7 хувийг өндөр настны, 11.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 9.7 хувийг цэргийн, 5.8 хувийг

тэжээгчээ алдсаны тэтгэвэр ээзлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс өндөр настны тэтгэвэр 25.2 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 30.4 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 42.4 хувиар буурч, цэргийн тэтгэвэр 28.4 хувиар өсчээ. (Зураг I.8).

Нийгмийн даатгалд 2012 оны 1 дүгээр сард 115.6 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 68.8 мянга буюу 59.5 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 46.8 мянга буюу 40.5 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 40.5 мянга буюу 53.9 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 24.4 мянга буюу 54.9 хувь, төсөвт байгууллагынх 16.1 мянга буюу 52.6 хувиар нэмэгджээ.

**Нийгмийн халамж:**

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны 1 дүгээр сард 146.2 мян.хүнд 5.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 10.6 мян.хүн буюу 7.8 хувиар өсч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 250.0 сая төг буюу 4.8 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 46.3 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 36.7 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 7.9 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 8.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 0.7 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөж буй иргэд байна. (Зураг I.9).

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны 1 дүгээр сард олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 2.9 тэрбум төг буюу 53.1 хувийг халамжийн тэтгэвэрт, 1.7 тэрбум төг буюу 32.3 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд , 390.3 сая төг буюу 7.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд , 367.6 сая төг буюу 6.8 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 33.5 сая төг буюу 0.6 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна. (Зураг I.10).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны 1 дүгээр сард 53.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 мян.хүн буюу 4.8 хувь,

Зураг-I.8

***Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар***




Зураг-I.9

***Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар***




Зураг-I.10

***Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар***



олгосон тэтгэврийн хэмжээ 131.9 сая төг буюу 4.8 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 17.7 мян.хүн хамрагдсаны 27.6 хувь нь ахмад настан, 20.1 хувь нь алдар цолтой ахмад настан, 8.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 29.0 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 14.5 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

"Хүний хөгжил" сангаас 2012 оны 1 дүгээр сард 32.9 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.6 сая иргэнд олгожээ.

## I.4 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 6015 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 852 эх буюу 16.5 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 6033 болж, 843 хүүхэд буюу 16.2 хувиар өслөө (Зураг I.11).

Энэ хугацаанд нэг хүртэлх насандаа 105 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хүүхэд буюу 11.7 хувь, 1-5 хүртэлх насны 21 хүүхэд эндэж, 5 хүүхэд буюу 31.3 хувиар нэмэгджээ (Зураг I.12). Жирэмслэлт болон төрөлтийн улмаас 4 эх эндсэн байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2012 оны 1 дүгээр сард 17 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Сүхбаатар (55), Өмнөговь (42), Хэнтий (39), Хөвсгөл (38), Архангай, Булган (32) аймагт улсын дунджаас 15-38 хүүхдээр, Дорноговь (29), Орхон (27), Завхан (25), Баян-Өлгий, Увс (23) Төв (22) аймагт 5-12 хүүхдээр илүү байна.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насандаа* эндсэн хүүхдийн тоо 21 болж, өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Халдварт өвчнөөр 2012 оны 1 дүгээр сард 3815 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 765 хүн буюу 25.1 хувиар нэмэгдэхэд тэмбүү өвчнөөр өвчлөгчдийн тоо 102 хүн буюу 39.4 хувь, трихомониаз өвчнөөр 69 хүн буюу 24.9 хувь, салхин цэцгээр 69 хүн буюу 24.8 хувь, сүрьеэгээр 34 хүн буюу 12.6 хувь, гонококкт халдвараар 39 хүн буюу 10.6 хувь, цусан суулгаар 3 хүн буюу 2.7 хувь, вирүст хепатитээр 101 хүн буюу 7.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

10 000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2012 оны 1 дүгээр сард улсын дунджаар 13 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүнээр нэмэгдэв (Зураг I.13).

Тайлбар: *Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 365 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.

Зураг-I.11

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**




Зураг-I.12

**Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**




Зураг-I.13

**10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**



Улаанбаатар хотод 2012 оны 1 дүгээр сард ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 102 болов.

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 1406 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 26 хүн буюу 1.8 хувиар буурчээ (Зураг I.14). Эмнэлэгт нас барсан хүний тоо энэ оны 1 дүгээр сард 365 болж, өмнөх оны мөн үеийнхээс 42 хүн буюу 13.0 хувиар нэмэгдэв. Энэ нь нийт нас баралтын 26.0 хувийг эзэлж байна.

Зураг-I.14




Эмнэлэгт 2012 оны 1 дүгээр сард 64.4 мян.хүн хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 7351 хүн буюу 12.9 хувиар нэмэгджээ.

Хувийн эмнэлгүүд 2012 оны 1 дүгээр сард 103.7 мян.хүнд үйлчилж, 2.8 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 68.1 хувиар өсч, төлбөрт үйлчилгээний хэмжээ 2.2 дахин өсөв.

## I.5. Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 2265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 413 хэргээр буюу 22.3 хувиар өсчээ (Зураг I.15). Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг (255), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (110), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (20) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг-I.15




Бүртгэгдсэн гэмт хэргийн 58.6 хувь нь нийслэлд, 40.2 хувь нь аймгуудад, 0.8 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.4 хувь нь бусад газарт 2012 оны 1 дүгээр сард бүртгэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Сүхбаатар аймагт 2 дахин, Орхон аймагт 80.5 хувь, Завхан аймагт 79.2 хувь, Хэнтий аймагт 76.3 хувь, Хөвсгөл аймагт 71.0 хувь, Баян-Өлгий аймагт 68.0 хувь, Баянхонгор аймагт 53.1 хувь, Өмнөговь аймагт 40.0 хувь, Говь-Алтай аймагт 35.0 хувь, Өвөрхангай аймагт 31.0 хувь, Сэлэнгэ аймагт 23.6 хувь, Дархан-Уул аймагт 21.2 хувь, Дундговь аймагт 13.0 хувь, Төв аймагт 12.5 хувь, Булган аймагт 9.5 хувь, Улаанбаатар хотод 28.0 хувиар нэмэгдэж, харин Увс аймагт 61.3 хувь, Ховд аймагт 48.0 хувь, Говьсүмбэр аймагт 20.0 хувь, Дорноговь аймагт 18.0 хувь, Архангай аймагт 8.3 хувь, Дорнод аймагт 2.0 хувиар буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 75 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 48 хэрэг буюу 2.8 дахин нэмэгдсэн байна. Малын хулгайн 175 гэмт хэрэг бүртгэгдэн нийт гэмт хэргийн 7.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 37 хэрэг буюу 26.8 хувиар өсчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 50.1 хувийг хүндэвтэр, 39.3 хувийг хөнгөн, 8.6 хувийг хүнд, 2.0 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс хүндэвтэр хэргийнх

2.3 пункт, онц хүнд хэргийнх 0.4 пунктээр нэмэгдэж, хөнгөн хэргийнх 1.5 пункт, хүнд хэргийнх 1.2 пунктээр буурсан байна (Зураг I.16).

18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын дунджаар 2012 оны 1 дүгээр сард 12 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 хэрэг буюу 20.0 хувиар нэмэгдэв.

Түүнчлэн сэжигтэн нь тодорхойгүй байсан 784 хэргийн 265 буюу 33.8 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 4.0 пунктээр, нийслэлийн хэмжээнд 10.7 пунктээр буурав. (Зураг I.17).

Хүүхэд оролцсон хэрэг 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 81.6 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 66.4 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 12.6 хувь, бүлэглэн үйлдсэн хэрэг 28.2 хувиар өсчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2012 оны 1 дүгээр сард 1641 байгаагийн 114 буюу 6.9 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 236 буюу 14.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 5.2 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өсчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын эзлэх хувь 2012 оны 1 дүгээр сард 11.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 пункт, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 10.2 хувь болж 3.0 пункт, малчдынх 9.9 хувь болж 2.1 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийн эзлэх хувь 55.3 болж 6.6 пункт, төрийн албан хаагчдынх 4.2 хувь болж 0.1 пункт, төрийн бус байгууллагын ажилтан 1.1 хувь болж 0.5 пунктээр буурсан бол оюутан, сурагчдынх 6.5 хувь болж өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь авч үзэхэд 2012 оны 1 дүгээр сард 34.9 хувь нь гэр, орон сууцанд, 14.8 хувь нь гудамж, талбайд, 14.7 хувь нь олон нийтийн газарт, 6.2 хувь нь авто замд, 7.6 хувь нь аж ахуйн нэгжид, 2.3 хувь нь төрийн байгууллагад, 1.5 хувь нь төрийн бус байгууллагад, 1.3 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 16.7 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Зураг-I.16

**Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**




Зураг-I.17

**Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**




Зураг-I.18

**Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**



Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2012 оны 1 дүгээр сард 707 хүн гэмтэж, 199 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 61 буюу 9.4 хувиар, нас барсан хүний тоо 20 буюу 11.2 хувиар өссөн байна (Зураг I.18).

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2012 оны 1 дүгээр сард 3.8 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 0.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 243.1 сая төг буюу 6.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 307.4 сая төг буюу 62.1 хувиар өссөн байна (Зураг I.19). Нийт нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ нэмэгдэхэд хувийн өмчит байгууллагынх 326.3 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 97.8 хувь буюу 3.7 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2012 оны 1 дүгээр сард 2079 байгаагийн 123 буюу 5.9 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 796 буюу 38.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас нийт 7 байгууллагад хохирол учирсны 4 нь төрийн, 1 нь төрийн бус, 2 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2012 оны 1 дүгээр сард 9.5 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 1.2 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 613 буюу 6.1 хувиар буурч, баривчлагдсан хүний тоо 164 буюу 16.5 хувиар өссөн байна.

Зураг-I.19




Зураг-I.19




## I.6. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Тогтвортой амьжиргаа-II” төслийн хэрэгжилт

“Тогтвортой амьжиргаа-II” төслийн зорилго нь эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, байгаль цаг уурын эрсдэлд малчдын бэлэн байх чадварыг нэмэгдүүлэх, алслагдсан орон нутагт жижиг зээлийн үйлчилгээг хүргэх замаар амьжиргааг баталгаажуулах, тогтворжуулахад улсын хэмжээнд иргэдийн хэрэгцээ, оролцоонд тулгуурласан механизмыг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно.

“Тогтвортой амьжиргаа” төслийг гурван үе шаттайгаар 12 жилийн хугацаатай хэрэгжүүлж байгаа бөгөөд 2002-2007 онд төслийн нэгдүгээр үе шат буюу “Тогтвортой амьжиргаа-I” төслийг Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс аймагт хэрэгжүүлж, 2008 оноос төслийн хоёрдугаар үе шат “Тогтвортой амьжиргаа-II” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү үе шат нь бүх аймаг болон нийслэлийн хэмжээнд 2012 он хүртэл үргэлжилнэ.

Төслийн хүрээнд 2011 онд нийт 9.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, үүнээс 4.1 тэрбум.төг буюу 44.1 хувийг бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чиглэлд, 2.6 тэрбум.төг буюу 28.4 хувийг дэд бүтцийн, 1.9

тэрбум.төг буюу 20.8 хувийг боловсролын, 619.0 сая.төг буюу 6.7 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулжээ (Зураг I.20).

Ерөнхий боловсролын сургууль засварлан тохижуулахад 629.1 сая.төг, эмнэлгийн байр шинээр барих, өргөтгөх, засварлан тохижуулахад 299.1 сая.төг, худаг шинээр барих, сэргээн засварлахад 462.7 сая.төг, эмнэлгүүдэд оношлогооны багаж, төхөөрөмж худалдан авахад 262.1 сая.төг, орон нутгийн зам шинээр барих, сэргээн засварлахад 74.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Энэхүү төслийн үр шимийг хүртсэн нийт 1482.5 мянган хүний 49,7 хувь буюу 737.2 мянга нь эмэгтэйчүүд, 13,3 хувь буюу 197.3 мянга нь ядуу иргэд байна.

Энэ хугацаанд 242 хүнийг байнгын, 553 хүнийг улирлын, 10256 хүнийг түр ажлын байраар хангасан байна.

Зураг-I.20

**"Тогтвортой амьжиргаа-II" төслийн нийт хөрөнгө оруулалт, салбараар 2011 оны байдлаар, хувиар**




Зураг-I.21

**"Тогтвортой амьжиргаа-II" төслийн үр шимийг хүртсэн хүний тоо, салбараар, 2011 оны байдлаар, хувиар**




## II.Макро эдийн засгийн тойм

### II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

ДНБ оны үнээр өмнөх оны мөн үеийнхээс 2011 оны эхний улиралд 19.8 хувь, эхний хагас жилд 29.4 хувь, эхний 3 улиралд 31.7 хувь, жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 28.7 хувиар өсч, 10829.7 тэрбум төгрөгт хүрлээ.

ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оны мөн үеийнхээс 2011 оны эхний улиралд 9.8 хувь, эхний хагас жилд 14.0 хувь, эхний 3 улиралд 16.5 хувь, харин жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 4881.4 тэрбум төгрөгт хүрч, 17.3 хувиар өслөө (Зураг II.1).

Уг өсөлтөд аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 19.8 хувь, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 10.1 хувь, үйлчилгээний салбар оны үнээр 29.2 хувь, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 17.1 хувиар өссөн байна.

Зураг-II.1




* урьдчилсан гүйцэтгэл

## II.2. Үнэ

### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар өслөө (Хүснэгт 1).

Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 4.9 хувь, тээврийн бүлгийнх 5.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Түүнчлэн согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 2.0 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 2.3 хувь, гэр ахуйн тавилга, барааных 1.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 1.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 1.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 2.4 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 1.2 хувь өсч, боловсролын үйлчилгээний бүлгийн дүн тогтвортой, харин орон сууц, ус, цахилгаан, түлш болон холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх тус бүр 0.2 хувиар буурсан байна.

Хэрэглээний үнийн улсын индекс 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувь өссөний дотор хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүн 14.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 12.9 хувь, тээврийн бүлгийнх 18.4 хувь, боловсролын үйлчилгээнийх 9.9 хувь, хүнсний бараа, ундаа, усных 8.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 8.3 хувиар нэмэгджээ.

Хүснэгт-II.1

**Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | 2012 I / 2011 I % | 2012 I / 2011 XII % |
|---|---|---|---|
| Ерөнхий индекс | 100.0 | 110.2 | 102.8 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 29.3 | 108.6 | 104.9 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.2 | 103.4 | 102.0 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.1 | 114.5 | 102.3 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 12.3 | 112.9 | 99.8 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 4.7 | 107.3 | 101.6 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 103.9 | 101.5 |
| Тээвэр | 12.2 | 118.4 | 105.3 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 99.7 | 99.8 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.8 | 102.3 | 101.2 |
| Боловсролын үйлчилгээ | 4.7 | 109.9 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.6 | 108.3 | 102.4 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.1 | 105.9 | 101.2 |

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 1 дүгээр сард оны эхнээс 3.0 хувиар өссөн бол 2012 оны 1 дүгээр сард 2.8 хувь болж, өсөлт 0.2 пунктээр доогуур байна (Зураг II.2).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас бүх аймаг болон нийслэлд 1.4-3.6 хувиар өсчээ (Зураг II.2).

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас бүх аймагт 0.1-17.9 хувиар өслөө. Харин Увс (17.9%) аймагт хамгийн ихээр өссөн байна.

Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ Булган (0.3%), Дундговь (0.1), Сэлэнгэ (2.4%), Хэнтий (0.2%), Дархан-Уул (0.5) аймагт буурч, Дорноговь, Өвөрхангай, Сүхбаатар аймагт тогтвортой, бусад аймагт 0.3-6.5 хувиар өсчээ.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ Баян-Өлгий (0.1%), Говь-Алтай (0.2), Сэлэнгэ (1.0) аймагт буурч, Дорноговь аймагт тогтвортой, бусад аймагт 0.1-21.0 хувиар өссөн байна. Харин Говьсүмбэр (21.0) аймагт хамгийн өндөр өсөлт гарчээ.

Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ Архангай (2.0), Говь-Алтай (0.6%), Завхан (0.1%), Сэлэнгэ (8.5), Хөвсгөл (9.9) аймагт буурч, Баян-Өлгий, Дорноговь аймагт тогтвортой, бусад аймагт 0.1-25.3 хувиар өссөн байна. Харин Ховд аймагт (25.3) хамгийн өндөр өсөлттэй байв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас Ховд аймагт хамгийн их буюу 3.6 хувиар өслөө. Энэ өсөлтөд хүнсний барааны бүлгийн үнэ 6.8 хувь, үүний дотор мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 12.0 хувь, төмс, хүнсний ногооных 25.3 хувь, тээврийн бүлгийнх 5.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс бүх аймагт 6.7-13.6 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 2.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний үнийн ерөнхий индекс өмнөх сарынхаас 2.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 6.0 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 3.0 хувь, тээврийн бүлгийнх 4.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 2.6 хувь, гэр ахуйн тавилга, барааных 1.0 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 1.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 1.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 2.3 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 1.3 хувиар өсчээ. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн дүн 1.4 хувиар буурч,

Зураг-II.2




*- Тайлбар: ХҮИ-ийн тооцоонд бараа, үйлчилгээний жинг 2010 оны ӨНЭЗС-аар шинэчилж, сагсны нэр төрлийг УБ хотод 329, аймагт 214 болгож өргөжүүлэн, 2010 оны 12 сарыг суурь үеэр авсан.*

Зураг-II.3



эдгээрээс бусад бүлгийн үнэ тогтвортой байв (Зураг II.4).

Улаанбаатар хотод 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 43.5 хувийнх нь үнэ өсч, 3.3 хувийнх нь үнэ буурч, 53.2 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 73.1 хувь буюу 68 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг-II.4




Хүснэгт-II.2

**Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2012 оны 1 дүгээр сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Үнийн өөрчлөлт, % | Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт |
|---|---|---|
| Хүнсний бараа, ундаа, ус | 6.0 | Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 12.2 хувь сүү, сүүн, бүтээгдэхүүнийх 4.7 хувь, жимс, жимсгэнийх 8.1 хувь, төмс, хүнсний ногооных 2.0 хувь, сахар, чихрийнх 3.0 хувь, хүнсний бусад барааны дэд бүлгийнх 3.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. |
| Согтууруулах ундаа, тамхи | 2.6 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 1.2 хувь, тамхиных 4.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв. |
| Хувцас, бөс бараа, гутал | 3.0 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд хөвөн бөс, барааны дэд бүлгийн үнэ 6.7 хувь, бүх төрлийн хувцасных 3.5 хувь, бүх төрлийн гутлынх 1.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ. |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | -1.4 | Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн бууралтад 1 уут түлшний модны үнэ 3.3 хувь, нүүрсний 5.4 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 1.0 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд оёмол, нэхмэл эдлэл болон гэр ахуйн шилэн эдлэл, сав, суулганы үнэ тус бүр 3.6 хувь, гэр ахуйн жижиг барааны үнэ 1.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв. |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 1.3 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 1.8 хувь, шүдэнд ломбо тавих хөлс 9.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. |
| Тээвэр | 4.6 | Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд автобензиний үнэ 11.9-13.0 хувь, дизелийн түлшний үнэ 10.9 хувь, хот доторхи таксины хөлс 16.7 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв. |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 1.5 | Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд флаш дискний үнэ 3.2 хувь, тоглоомынх 4.7 хувь, кино театрын үзвэрийн үнэ 6.4 хувь, ном, бичгийн хэрэгслийнх 3.5 хувиар өссөн нь нөлөөлөв. |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.3 | Энэ бүлгийн үнийн өсөлт нь цайны газрын хоолны үнэ 3.5 хувь, зочид буудлын өрөөний хөлс 8.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна. |
| Бусад бараа, үйлчилгээ | 1.3 | Бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтөд эмэгтэй хүний үс тайрах хөлс 11.4 хувь, нийтийн халуун усанд орох хөлс 13.3 хувь, үсний шампуний үнэ 2.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ. |

## Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2012 оны 1 дүгээр сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь аймагт хамгийн бага буюу 27.0-28.7 мян.төг, Архангай, Сэлэнгэ, Орхон, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 38.0-41.0 мян.төг, адууны ширнийх Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 32.0-35.0 мян.төг, Баян-Өлгий, Төв, Хэнтий, Сүхбаатар аймагт хамгийн их буюу 43.5-45.0 мян.төг, ямааны цагаан ноолуурын үнэ Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Завхан аймагт хамгийн бага буюу 40.0-45.0 мян.төг, Баян-Өлгий, Төв, Орхон, Хөвсгөл, Архангай аймагт хамгийн их буюу 50.0-55.0 мян.төг байна

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Баян-Өлгий, Баянхонгор, Орхон, Сэлэнгэ, Увс, Өвөрхангай, Дорнод аймагт өмнөх сарынхаас 2.0-6.8 мян.төг буюу 6.7-23.7 хувиар өсч, харин Завхан, Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Төв аймагт өмнөх сарын түвшинд байв.

Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Сүхбаатар, Завхан, Төв, Хөвсгөл, Орхон аймагт өмнөх сарынхаас 5.0-16.0 мян.төг буюу 12.5-64.0 хувиар өсч, Булган, Увс, Дархан-Уул аймагт өмнөх сарын түвшинд байв.

Ямааны цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ Баян-Өлгий, Орхон, Өмнөговь, Хөвсгөл, Архангай аймагт өмнөх сарынхаас 2.0-10.0 мян.төг буюу 4.2-22.2 хувиар өсч, харин Дундговь, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод 3.0-5.0 мян.төг буюу 6.0-11.1 хувиар буурчээ.

Зураг-II.5

**Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.төг**




**Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.төг**



**Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.төг**




**Хонины ноостой нэхийний зах зээлийн дундаж үнэ,жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.төг**




## Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ 2012 оны 1 дүгээр сард

Улаанбаатар хотод 2012 оны 1 дүгээр сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 37 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

Өмнөх оны мөн үеийнхээс эх орны үйлдвэрийн 50 кг-ын савлагаатай цементний үнэ 2012 оны 1 дүгээр сард 3.3 мян.төг буюу 56.0 хувь, улаан тоосгоных 60 төг буюу 50.0 хувь, хөнгөн бетоны үнэ 19.5 мян.төг буюу 20.4 хувь, хуурай палкны үнэ 4.0 мян.төг буюу 20.0 хувь, шалны банзных (ховилгүй) 10.0 мян.төг буюу 7.1 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн хар цаасны үнэ (чулуутай) 5.5 мян.төг буюу 37.9 хувиар өсчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн хар цаасны (чулуугүй) үнэ 2.0 мян.төг буюу 28.6 хувь, крантных 10.0 мян.төг буюу 25.0 хувь, 50 кг-ын савлагаатай цементнийх 1.5 мян.төг буюу 23.1 хувь, уян шүршүүрнийх 3.0 мян.төг буюу 20.0 хувь, шахмал шалных 2.0 мян.төг буюу 20.0 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 12.5 хувь, өдрийн гэрлийнх (суурьгүй) 0.2 мян.төг буюу 11.1 хувь, шаазан угаагуурынх 5.0 мян.төг буюу 9.1 хувь, цонхны шилнийх (нөлөөгүй) 1.0 мян.төг буюу 8.3 хувь, төмөр хаалганых 3.0 мян.төг буюу 2.2 хувиар өсч, харин тараган цавуу болон дүүжин таазны үнэ тус бүр 0.5 мян.төг буюу 12.5 хувиар буурчээ. БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 1.0 мян.төг буюу 22.2 хувиар өсөв.

Өмнөх сарынхаас 2012 оны 1 дүгээр сард эх орны үйлдвэрийн 50 кг-ын савлагаатай цементний үнэ 2.6 мян.төг буюу 39.2 хувь, шалны банзных (ховилгүй) 8.0 мян.төг буюу 5.6 хувь, хуурай палкных 1.0 мян.төг буюу 4.3 хувиар өсчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн цонхны шил (нөлөөгүй) 2.0 мян.төг буюу 13.3 хувиар буурч, крант 5.0 мян.төг буюу 11.1 хувиар өссөн байна. Бусад материалын үнэ тогтвортой байлаа.

### Орон сууцны үнийн индекс

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2011 оны 4 дүгээр улиралд 2010 оны 4 дүгээр улирлынхаас 38.1 хувь, 2011 оны 3 дугаар улирлынхаас 18.5 хувь өсчээ.

Орон сууцны үнийг дүүргээр авч үзэхэд 2011 оны 4 дүгээр улиралд 2010 оны 4 дүгээр улирлынхаас Сонгинохайрхан дүүрэгт (31.6%), Хан-Уулд (33.7%), Баянгол (35.4%), Баянзүрхэд (38.8%), Чингэлтэйд (44.7%),

Сүхбаатар дүүрэгт (47.3%) өссөн, мөн 2011 оны 3 дугаар улирлынхаас Чингэлтэй дүүрэгт (17.1%), Сонгинохайрханд (17.3%), Хан-Уулд (17.9%), Баянголд (18.0%), Сүхбаатарт (19.1%), Баянзүрх дүүрэгт (20.4%) өссөн байна (Зураг II.6).

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2011 оны 4 дүгээр улиралд 2010 оны 4 дүгээр улирлынхаас төвийн 6 дүүрэгт 30.2-54.4 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 32.0-52.2 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 26.3-42.7 хувиар нэмэгдсэн байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2011 оны 4 дүгээр улиралд 2011 оны 3 дугаар улирлынхаас төвийн 6 дүүрэгт 11.5-22.3 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 17.4-20.0 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 15.6-19.7 хувиар нэмэгджээ.

Зураг-II.6

**Улаанбаатар хотын орон сууцны үнийн индекс, төвийн 6 дүүргээр, 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар, хувиар**




Зураг-II.7

**Мөнгөний нийлүүлэлт (М2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)**




## II.3. Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2012 оны 1 дүгээр сарын эцэст 6150.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 262.1 тэрбум төг буюу 4.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1344.7 тэрбум төг буюу 28.0 хувиар өсчээ (Хүснэгт II.3).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2012 оны 1 дүгээр сарын эцэст 46.5 хувийг төгрөгийн хадгаламж, 16.7 хувийг гадаад валютын хадгаламж, 18.0 хувийг төгрөгийн харилцах, 11.3 хувийг гадаад валютын харилцах, 7.5 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.7). Мөнгөний нийлүүлэлтэд гадаад валютын хадгаламжийн эзлэх хувь өмнөх сарынхаас 1.5 пункт, төгрөгийн хадгаламжийнх 1.1 пунктээр өсч, харин төгрөгийн харилцахын эзлэх хувь өмнөх сарынхаас 1.1 пункт, гадаад валютын харилцахынх 0.9 пункт, банкнаас гадуурх мөнгөнийх 0.6 пунктээр буурчээ.

Бага мөнгө 2012 оны 1 дүгээр сарын эцэст 1566.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 175.0 тэрбум төг буюу 10.1 хувиар буурав. Бага мөнгө өмнөх оны мөн үеийнхээс

Хүснэгт-II.3

**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 I | 2011 XII | 2012 I |
|---|---|---|---|
| **Мөнгөний нийлүүлэлт М2** | **4 805.5** | **6 412.3** | **6 150.1** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 67.4 | 37.0 | 28.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.7 | 4.9 | - 4.1 |
| **Нийт хадгаламж** | **3 065.9** | **3 890.3** | **3 888.3** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 65.9 | 41.1 | 26.8 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 11.2 | 2.0 | - 0.1 |
| **Төгрөгийн хадгаламж** | **2 236.6** | **2 912.4** | **2 861.5** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 80.3 | 45.5 | 27.9 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 11.7 | 3.7 | - 1.7 |
| **Валютын хадгаламж** | **829.3** | **977.9** | **1 026.8** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 36.6 | 29.6 | 23.8 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 9.9 | - 2.7 | 5.0 |

434.6 тэрбум төг буюу 38.4 хувиар нэмэгдэхэд төгрөгийн харилцах 369.9 тэрбум төг буюу 50.2 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2012 оны 1 дүгээр сарын эцэст 3888.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.0 тэрбум төг буюу 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 822.4 тэрбум төг буюу 26.8 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2012 оны 1 дүгээр сарын эцэст 2861.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 50.9 тэрбум төг буюу 1.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 624.9 тэрбум төг буюу 27.9 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2012 оны 1 дүгээр сарын эцэст 1026.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 48.9 тэрбум төг буюу 5.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 197.5 тэрбум төг буюу 23.8 хувиар нэмэгджээ (Хүснэгт II.3).

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 1 дүгээр сарын эцэст 657.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 56.4 тэрбум төг буюу 7.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 91.3 тэрбум төг буюу 16.1 хувиар өсчээ.

Нөөц мөнгө (М0) 2012 оны 1 дүгээр сарын эцэст 1553.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 106.4 тэрбум төг буюу 6.4 хувиар буурлаа. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2012 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 50.1 тэрбум төг буюу 5.3 хувиар буурч, 898.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2012 оны 1 дүгээр сарын эцэст 8156.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 495.9 тэрбум төг буюу 5.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2131.2 тэрбум төг буюу 35.4 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 5649.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 7.8 тэрбум төг буюу 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2208.7 тэрбум төг буюу 64.2 хувиар өсчээ (Хүснэгт II.4).

Зээлийн өрийн үлдэглийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2012 оны 1 дүгээр сарын эцэст нийт зээлийн 3136.7 тэрбум төг буюу 55.5 хувь нь хувийн секторт, иргэдийнх 2472.5 тэрбум төг буюу 43.8 хувь, улсын байгууллагынх 19.0 тэрбум төг буюу 0.4 хувь, бусад санхүүгийн байгууллагынх 13.7 тэрбум

Зураг-II.8

**Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, жил бүрийн 1 дүгээр сарын эцсийн байдлаар**




Зураг-II.9

**Мөнгөний нийлүүлэлт (М2), бага мөнгө (М1) болон бараг мөнгөний өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)**




Хүснэгт-II.4

**Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлсарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 I | 2011 XII | 2012 I |
|---|---|---|---|
| **Зээлийн өрийн үлдэгдэл** | **3 440.3** | **5 641.2** | **5 649.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 28.6 | 72.9 | 64.2 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 5.4 | 3.7 | 0.1 |
| **Чанаргүй зээл** | **361.5** | **330.0** | **328.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 21.1 | - 11.9 | - 9.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | - 3.4 | - 3.8 | - 0.6 |
| **Хугацаа хэтэрсэн зээл** | **103.0** | **73.7** | **73.8** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 15.9 | - 18.6 | - 28.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 14.1 | 3.1 | 0.1 |
| **Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь** | **10.5** | **5.8** | **5.8** |
| Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь | 3.0 | 1.3 | 1.3 |

төг буюу 0.2 хувь, бусад байгууллагынх 7.1 тэрбум төг буюу 0.1 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 328.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.0 тэрбум төг буюу 0.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 33.5 тэрбум төг буюу 9.3 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж, өмнөх сарынхаас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеийнхээс 4.7 пунктээр буурчээ (Хүснэгт II.4).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 1 дүгээр сарын эцэст 73.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төг буюу 0.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 29.2 тэрбум төг буюу 28.3 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарын түвшинд, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 пунктээр буурсан байна (Хүснэгт II.4).

Энэ оны 1 дүгээр сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 67.8 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банканд ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2011 оны 12 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 0.6 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 пунктээр буурч, жилийн хүү 15.5 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 пунктээр буурч, жилийн хүү 12.1 хувь боллоо (Зураг II.11).

Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 81.3 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 64.2 сая ам.доллараар нэмэгдэж, 2192.6 сая ам.долл болсон нь манай улсын импортын 19.6 долоо хоног буюу 4.9 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.12).

## Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2012 оны 1 дүгээр сард 22 өдөр явагдаж, 4.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 4.8 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 4.3 тэрбум төг буюу 47.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 тэрбум төг буюу 8.8 хувиар

Зураг-II.10

**Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг**




Зураг-II.11

**Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар**




Зураг-II.12

**Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл**



буурчээ. Арилжсан үнэт цаасны тоо 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 0.7 сая ш буюу 12.9 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 сая ш буюу 26.2 хувиар буурлаа.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2012 оны 1 дүгээр сард 20445.1 болж, өмнөх сарынхаас 598.4 нэгжээр өсчээ (Зураг II.13). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2012 оны 1 дүгээр сард 1922.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 176.0 тэрбум төг буюу 8.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 264.8 тэрбум төг буюу 11.7 хувиар буурлаа. (Зураг II.14).

“ЖЕНКО ТУР БЮРО” хувьцаат компанийн 2.0 сая ш хувьцаа 2012 оны 1 дүгээр сард арилжигдсан нь хамгийн идэвхтэй арилжаалсан үнэт цаас байв.

## Валютын ханш

Монгол банкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 1 дүгээр сард 1395.1 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 138.7 төг буюу 11.0 хувиар суларсан байна (Хүснэгт II.3). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 3.8 хувь, 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 1.5 хувиар суларчээ (Зураг II.15).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 1 дүгээр сард 1801.0 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 124.8 төг буюу 7.4 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.0 хувиар суларч, 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 0.6 хувиар чангарсан байна (Зураг II.16).

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 1 дүгээр сард 220.9 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 30.5 төг буюу 16 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 4.0 хувь, 2012 оны

Зураг-II.13

**ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар**




Зураг-II.14

**Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг**




Хүснэгт-II.5

**Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**

| Үзүүлэлт | 2010 XII | 2011 XI | 2011 XII |
|---|---|---|---|
| **Ам. Доллар** | **1 256.4** | **1 374.2** | **1 395.1** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 13.7 | 11.4 | 11.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 1.8 | 3.8 | 1.5 |
| **Евро** | **1 676.2** | **1 811.6** | **1 801.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 19.5 | 11.1 | 7.4 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.7 | 1.0 | - 0.6 |
| **Юань** | **190.4** | **216.5** | **220.9** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 10.7 | 16.6 | 16.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.6 | 4.0 | 2.0 |
| **Рубль** | **41.6** | **43.7** | **44.5** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 14.8 | 9.3 | 7.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 4.0 | 1.9 | 1.8 |

Зураг-II.15

**Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.16

**Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**



1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.0 хувиар суларчээ (Зураг II.17).

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 1 дүгээр сард 44.5 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 төг буюу 7.0 хувь суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 1.9 хувь, 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 1.8 хувиар суларлаа (Зураг II.18).

Зураг-II.17

**Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




## II.4. Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 325.8 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 260.0 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 65.8 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа (Зураг I.8).

Төсвийн урсгал орлого 324.3 тэрбум төг, урсгал зардал 257.2 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 67.2 тэрбум төгрөгийн ашигтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс урсгал орлого 108.5 тэрбум төг буюу 50.3 хувь, урсгал зарлага 29.1 тэрбум төг буюу 12.7 хувиар өсчээ.

Зураг-II.18

**Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




### Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2012 оны 1 дүгээр сард төвлөрүүлсэн орлого 325.8 тэрбум төг болж өмнөх оны мөн үеийнхээс 106.4 тэрбум төг буюу 48.5 хувиар өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 90.3 хувийг татварын орлого, 9.2 хувийг татварын бус орлого, 0.3 хувийг тусламжийн орлого, 0.2 хувийг хөрөнгийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс татварын орлого болон тогтворжуулалтын сангийн орлогын эзлэх хувь тус бүр 1.4 пунктээр буурч, татварын бус орлогынх 2.5 пункт, тусламжийн орлогынх 0.3 пунктээр өсчээ.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 93.2 тэрбум төг буюу 46.3 хувиар нэмэгдэхэд хэдийгээр дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 18.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурсан ч гадаад худалдааны татварын орлого 51.8 тэрбум төг буюу 3.8 дахин, бусад татварын орлого

Зураг-II.19

**Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, тэрбум төг**



45.1 тэрбум төг буюу 3.2 дахин, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 17.1 тэрбум төг буюу 72.8 хувь, хүн амын орлогын албан татварын орлого 6.5 тэрбум төг буюу 50.5 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 3.9 тэрбум төг буюу 17.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 15.3 тэрбум төг буюу 2.0 дахин нэмэгдэхэд навигацын орлого 2.2 тэрбум төг, газрын тосны орлого 0.6 тэрбум төг буюу 43.1 хувиар буурсан ч төсөвт газрын өөрийн орлого 8.5 тэрбум төг буюу 2.1 дахин, бусад нэр заагдаагүй орлого 6.2 тэрбум төг буюу 5.4 дахин, хүү, торгуулийн орлого 3.2 тэрбум төг буюу 3.0 дахин, хувьцааны ногдол ашгийн орлого 0.2 тэрбум төг буюу 606.5 дахин өссөн голлон нь нөлөөлжээ (Хавсралт 5).

**Төсвийн зарлага**

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 260.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 13.5 тэрбум төг буюу 5.5 хувиар өсөхөд эргэж төлөгдөх цэвэр зээл 9.5 тэрбум төг, хөрөнгийн зардал 6.1 тэрбум төг буюу 45.8 хувиар буурсан хэдий ч татаас ба шилжүүлгийн зардал 19.3 тэрбум төг буюу 15.5 хувь, бараа, үйлчилгээний зардал 8.3 тэрбум төг буюу 8.8 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 1.5 тэрбум төг буюу 15.3 хувиар өссөн нь шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 98.9 хувь, хөрөнгийн зардал 2.8 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл -1.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс эргэж төлөгдөх цэвэр зээлийн эзлэх хувь 3.7 пункт, хөрөнгийн зардлынх 2.6 пунктээр буурч, урсгал зардлынх 6.4 пунктээр өсчээ (Хавсралт 5).

**Хөрөнгийн зардал**

Хөрөнгийн зардалд 2012 оны 1 дүгээр сард 7.3 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 6.1 тэрбум төг буюу 45.8 хувиар буурчээ. Үүнд гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 5.0 тэрбум төг, дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 2.3 тэрбум төг байна.

## II.5 Гадаад худалдаа

Монгол Улс 2012 оны 1 дүгээр сард дэлхийн 94 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 735.2 сая ам.долл, үүнээс экспорт 240.3 сая ам.долл, импорт 494.9 сая ам.долларт хүрчээ (Зураг X.1). Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 178.4 сая ам.долл буюу 32.0 хувь, үүний дотор импортын хэмжээ 146.7 сая ам.доллараар буюу 42.1 хувь, экспортын хэмжээ 31.7 сая ам.долл буюу 15.2 хувиар өсчээ.

Өмнөх оны 1 дүгээр сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 51.6 хувь нь БНХАУ-д, 16.4 хувь нь ОХУ-д, үлдсэн 32.0 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2012 оны 1 дүгээр сард нийт бараа эргэлтийн 42.3 хувь нь БНХАУ, 23.9 хувь нь ОХУ, 33.8 хувь нь бусад улсад ногдож байна. Өмнөх оны мөн үеийнхээс БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 9.3 пунктээр буурч, ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 7.5 пункт, бусад улсынх 1.8 пунктээр өсчээ.

Зураг-II.20

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая ам.долл




Гадаад худалдааны тэнцэл 2011 оны 1 дүгээр сард 139.6 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2012 оны 1 дүгээр сард 254.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 115.0 сая ам.долл буюу 82.4 хувиар өсчээ. Үүнд импортын өсөлт экспортынхоос 26.9 пунктээр илүү өссөн байгаа нь нөлөөлжээ.

## Экспорт

Манай улс 2012 оны 1 дүгээр сард нийт 31 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 89.6 хувь, Канад улсад 2.9 хувь, ОХУ-д 2.1 хувь, Судан улсад 1.4 хувь, Энэтхэг улсад 1.3 хувь, БНСУ-д 1.0 хувь, Вьетнам улсад 0.6 хувь, ХБНГУ болон Их Британи улс тус бүрт 0.3 хувь ногдож байгаа нь нийт экспортын 99.5 хувийг эзэлж байна (Зураг II.21).

Экспортын 97.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна (Зураг II.22).

Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 31.7 сая ам.долл буюу 15.2 хувиар нэмэгдэхэд экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт 28.1 сая ам.долл, үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийнх 4.3 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийнх 2.9 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэлийнх 1.4 сая ам.доллараар өсч, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүнийх 2.5 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 1.0 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Экспортод гол нэрийн барааны эзлэх хувийн жинг авч үзэхэд нүүрс 32.2 хувь, зэсийн баяжмал 27.8 хувь, төмрийн хүдэр 15.7 хувь, боловсруулаагүй газрын тос 8.1 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.4 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 2.9 хувь, жоншны хүдэр, баяжмал 2.4 хувь, бусад бүтээгдэхүүн 7.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт экспортод зэсийн баяжмалын эзлэх хувийн жин 8.1 пункт, цайрын хүдэр, баяжмалынх 6.8 пункт, жоншны хүдэр, баяжмалынх 0.4 пунктээр буурч, нүүрснийх 13.0 пункт, төмрийн хүдрийнх 5.6 пункт, боловсруулаагүй газрын тосных 2.4 пункт, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 1.6 пунктээр өсчээ.

Экспорт 2012 оны 1 дүгээр сард бүхэлдээ валютын төлбөртэй худалдаагаар хийгдсэн байна.

Зураг-II.21

**Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар**




Зураг-II.22

**Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**




Хүснэгт-II.6

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.т

| | 2010 I | 2011 I | 2012 I |
|---|---|---|---|
| Нүүрс | 696.8 | 667.9 | 670.9 |
| Зэсийн баяжмал | 47.5 | 45.2 | 48.1 |
| Төмрийн хүдэр | 84.2 | 252.1 | 513.1 |
| Боловсруулаагүй газрын тос | 189.6 | 136.0 | 201.6 |
| Цайрын хүдэр, баяжмал | 12.6 | 19.1 | 8.0 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | 0.4 | 0.1 | 0.2 |

## Импорт

Манай улс 2012 оны 1 дүгээр сард нийт 93 оронтой импортын худалдаа хийсний 34.5 хувийг ОХУ-тай, 19.4 хувийг БНХАУ-тай, 10.2 хувийг АНУ-тай, 5.9 хувийг Япон улстай, 5.7 хувийг БНСУ-тай, ХБНГУ болон Белорусь улстай тус бүр 2.6 хувийг, Украин улстай 2.4 хувийг хийсэн нь нийт дүнгийн 83.3 хувийг эзэлж байна (Зураг II.23). Нийт импортод голлох улсуудын эзэлж байгаа хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ОХУ-ынх 9.8 пункт, АНУ-ынх 3.0 пункт, Белорусь улсынх 2.5 пункт, Украин улсынх 1.0 пунктээр өсч, БНХАУ-ынх 9.3 пункт, Япон улсынх 1.8 пункт, ХБНГУ-ынх 1.7 пунктээр буурчээ.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 146.7 сая ам.долл буюу 42.1 хувиар нэмэгдэхэд импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний импорт 79.7 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийнх 23.3 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 8.4 сая ам.долл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 7.1 сая ам.доллар, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийх 5.5 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 4.5 сая ам.доллараар өссөн нь нөлөөлөв.

Нийт импортын 29.8 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 21.9 хувийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 20.2 хувийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг, 5.3 хувийг үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, 5.2 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 3.6 хувийг хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 2.8 хувийг хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл, үлдсэн 11.2 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.24).

Өмнөх оны мөн үеийнхээс цахилгаан эрчим хүчний импортын биет хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 6.9 сая квт.ц, үнийн дүн 0.7 сая ам.долл, гурилын импортын биет хэмжээ 4.4 мян.т, үнийн дүн 0.6 сая ам.долл, суудлын автомашины импортын биет хэмжээ 0.8 мян.ш, үнийн дүн 8.8 сая ам.долл, автобензиний импортын биет хэмжээ 20.7 мян.т, үнийн дүн 34.3 сая ам.доллараар өсчээ (Зураг II.25).

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2012 оны 1 дүгээр сард 113.4 мян.т буюу

Зураг-II.23

**Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар**




Зураг-II.24

**Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**




Зураг-II.25



143.3 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 29.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс газрын тосны бүтээгдэхүүний импорт 44.1 мян.т буюу 1.6 дахин өссөн байна.

2012 оны 1 дүгээр сард газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ, Белорусь, Литва улсаас; гурилыг ОХУ болон Казахстан улсаас; элсэн чихрийг ХБНГУ, Малайз, Бразил, Тайланд улсаас; нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас; суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, АНУ-аас; ачааны автомашиныг АНУ, БНСУ, БНХАУ-аас голлон нийлүүлсэн байна.

Импортолсон барааны 83.2 хувийг валютын төлбөртэй худалдаа, 13.9 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 2.8 хувийг тусламжийн бараа, 0.1 хувийг зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа эзэлж байна.

## III. Үйлдвэрлэл, үйлчилгээ

### III.1 Мал аж ахуй

Том малын зүй бус хорогдол 2012 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 22.8 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 41.7 мян. толгой буюу 64.6 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр авч үзвэл адуу 1.5 мянга, үхэр 2.2 мянга, тэмээ 49, хонь 9.2 мянга, ямаа 9.8 мянга байна (Зураг III.1). Нийт хорогдсон малын 43.2 хувийг ямаа, 40.2 хувийг хонь эзэлж байна.

2012 оны 1 дүгээр сард Архангай аймагт оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь буюу 4.7 мянга, Ховд аймагт 0.2 хувь буюу 3.5 мянга, Увс аймагт 0.1 хувь буюу 2.5 мянга, Баянхонгор аймагт 0.1 хувь буюу 1.9 мянга, Дорнод аймагт 0.1 хувь буюу 1.5 мянга нь хорогдлоо. Улсын хэмжээнд хорогдсон малын 61.9 хувийг эдгээр аймагт хорогдсон мал эзэлж байна (Зураг III.2).

Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2012 оны 1 дүгээр сард 0.9 мян.толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 0.2 мян.толгой буюу 18.2 хувиар бага байна.

Зураг-III.1

**Зүй бусаар хорогдсон том малын тоо, аймгаар, 2012 оны 1 дүгээр сарын байдлаар, мян.толгой**




Зураг-III.2

**Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.толгой**




### I.2 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны 1 дүгээр сард 154.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 тэрбум төг буюу 5.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, металл агуулгаараа,

хайлуур жоншны баяжмал, молибдений баяжмал, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.6-74.2 хувь, нарийн боов, хивс, шар айраг, шохой, талх, амтат ус, ундаа, цахилгааны утас, самнасан ноолуур, жүүс, бетон дэр, гоймон, шавардлагын зуурмаг, бетон зуурмаг, цемент, малын мах, шахмал түлш зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.0 хувиас 10.8 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Харин төмрийн хүдэр, нүүрс, цайрын баяжмал, алт зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.8-32.3 хувь, ном, катодын зэс, архи, шингэн сүү, тараг, металл цувимал, металл бэлдэц, өлөн гэдэс, хиамны зүйл, спирт, тамхи, гурил зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.9-48.8 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны 1 дүгээр сард 344.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 60.6 тэрбум төг буюу 21.4 хувиар өссөн бөгөөд үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 42.6 тэрбум төг буюу 24.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 10.3 тэрбум төг буюу 15.4 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 7.7 тэрбум төг буюу 19.4 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр сард оны үнээр 355.4 тэрбум төг болж, үүний 183.7 тэрбум төг буюу 51.7 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 9).

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 57.1 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 29.7 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 13.2 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг 3). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр сард 202.9 тэрбум төг болж, 172.1 тэрбум төг буюу 84.8 хувийг, боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 105.6 тэрбум төг болж, 11.6 тэрбум төг буюу 11.0 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.

Зураг-III.3

**Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар, 2005=100%**




Зураг-III.4

**Түлш, эрчим хүчний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар, 2005=100%**




Зураг-III.5

**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар**



Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2012 оны 1 дүгээр сард 29.7 хувь болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.5 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 57.1 хувь болж, 3.3 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 13.2 хувь болж, 0.2 пунктээр буурлаа (Зураг III.5).

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2012 оны 1 дүгээр сарын эцэст 54843 болж, өмнөх оны мөн үеийнхээс 4649 хүн буюу 9.3 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1137 хүн буюу 7.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 3350 хүн буюу 16.2 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 162 хүн буюу 1.1 хувиар өслөө.

**II.3.Тээвэр.**

Төмөр замын тээврээр 2012 оны 1 дүгээр сард 1733.8 мян.т ачаа, давхардсан тоогоор 293.7 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 388.7 мян.т буюу 28.9 хувь, зорчигчдын тоо 0.7 мян.хүн буюу 0.3 хувиар өсчээ (Зураг III.6.а, III.6.б).

Өмнөх оны мөн үеийнхээс төмөр замаар тээсэн нийт ачааны хэмжээ 2012 оны 1 дүгээр сард 388.7 мянган тонноор өсөхөд дамжин өнгөрсөн ачааны хэмжээ 49.1 мян.т буюу 30.4 хувиар буурсан хэдий ч дотоодод тээвэрлэсэн ачаа 29.3 мян.т буюу 3.8 хувь, экспортын ачаа 325.3 мян.т буюу 2.1 дахин, импортын ачаа 83.2 мян.т буюу 72.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 36.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 13.7 пунктээр нэмэгдэхэд төмрийн хүдрийн тээвэрлэлт 296.5 мян.т буюу 2.2 дахин өссөн нь голлон нөлөөлжээ. Харин төмөр замаар дотоодод тээвэрлэсэн ачаа нийт ачаа тээвэрлэлтийн 45.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 11.0 пунктээр буурсан байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны 1 дүгээр сард 32.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.0 тэрбум төг буюу 31.9 хувиар өсчээ (Хүснэгт III.1).

Агаарын тээврээр 2012 оны 1 дүгээр сард 302.3 т ачаа, давхардсан тоогоор 46.2 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2012 оны 1 дүгээр сард 2821.8 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 96.2 мян.төг буюу 3.3 хувиар буурчээ. Хөдөлмөрийн бүтээмж уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 17.3 мян.төг буюу 0.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 86.9 мян.төг буюу 5.0 хувиар өслөө. Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт 260.2 мян.төг буюу 12.9 хувиар буурлаа.

Зураг-III.6.а

**Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.6.б

**Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.т**




Хүснэгт-III.1

Төмөр замын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

| Хугацаа, сараар | Тээврийн орлого, сая төг | Зорчигчдын тоо, мян.хүн | Тээсэн ачаа, мян.т |
|---|---|---|---|
| 2010 I | 19 860.5 | 257.9 | 1 277.8 |
| II | 18 766.2 | 294.5 | 1 169.5 |
| III | 21 037.8 | 248.3 | 1 198.9 |
| 2011 I | 24 937.1 | 293.0 | 1 345.0 |
| II | 20 375.4 | 272.0 | 1 209.4 |
| III | 24 280.0 | 284.3 | 1 430.6 |
| 2012 I | 32 900.5 | 293.7 | 1 733.8 |
| 2012 I / 2011 I % | 131.9 | 100.3 | 128.9 |

үеийнхээс тээсэн ачаа 173.7 т буюу 2.3 дахин, зорчигчдын тоо 9.7 мян.хүн буюу 26.5 хувиар өсчээ (Зураг III.7.а, III.7.б).

Агаарын тээврээр 2012 оны 1 дүгээр сард дотоодод зорчсон зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 5.0 мян.хүн буюу 44.2 хувиар, олон улсад зорчсон зорчигчдын тоо 4.7 мян.хүн буюу 18.6 хувиар өсчээ.

Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны 1 дүгээр сард 11.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 тэрбум төг буюу 28.2 хувиар өсчээ (Хүснэгт III.2).

Хүснэгт-III.2

Агаарын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

| Хугацаа, сараар | Тээврийн орлого, сая төг | Зорчигчдын тоо, мян.хүн | Тээсэн ачаа, т |
|---|---|---|---|
| 2010 I | 6 759.1 | 24.1 | 138.5 |
| II | 6 096.3 | 19.8 | 102.1 |
| III | 7 206.7 | 24.2 | 104.1 |
| 2011 I | 9 021.4 | 36.5 | 128.6 |
| II | 8 079.9 | 30.2 | 122.8 |
| III | 8 211.9 | 34.0 | 150.8 |
| 2012 I | 11 564.5 | 46.2 | 302.3 |
| 2012 I / 2011 I % | 128.2 | 126.5 | 235.0 |

Зураг-III.7.а

**Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.7.б

**Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мян.т**




## III.4. Нийтийн хоол, зочид буудал

**Нийтийн хоол.**

Нийтийн хоолны салбарын мэдээнд 2011 онд 600 аж ахуйн нэгж хамрагдсан нь уг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 61.0 хувийг эзэлж байна. Эдгээр аж ахуйн нэгжийн нийт орлого 2011 оны эцэст 40.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 4.8 тэрбум төг буюу 13.7 хувиар нэмэгдэхэд кафеных 2.2 тэрбум төг буюу 52.4 хувь, гуанзных 2.0 тэрбум төг буюу 53.3 хувь, баарных 1.2 сая төг буюу 52.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Харин орлогод 61.5 хувийг эзэлж байгаа рестораны орлого 0.5 тэрбум төгрөгөөр буурлаа

Нийтийн хоолны салбарын мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжийн нэг суудалд ногдох дундаж орлого 2011 оны эцэст дунджаар 1.6 сая төг болж, өмнөх оныхоос 63.0 мян.төг буюу 4.1 хувиар өсчээ. Өмнөх оныхоос рестораны нэг суудалд ногдох дундаж орлого 190.4 мян.төг буюу 6.8 хувиар буурч, харин кафеных 144.1 мян.төг буюу 15.3 хувь, гуанзных 329.2 мян.төг буюу 43.0 хувь, баарных 270.3 мян.төг буюу 56.2 хувиар өсчээ (Хүснэгт 1).

Хүснэгт-III.3

**Нийтийн хоолны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эцэст**

| Үзүүлэлт | Орлого (сая төг) | | | Суудлын тооя | | | Нэг суудалд ногдох дундаж орлого (мян.төг) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 |
| Ресторан | 10 262.6 | 25 153.3 | 24 613.3 | 8 456 | 8 971 | 9 418 | 1 213.6 | 2 803.8 | 2 613.4 |
| Кафе | 5 603.9 | 4 212.1 | 6 420.1 | 5 378 | 4 466 | 5 905 | 1 042.0 | 943.1 | 1 087.2 |
| Баар | 1 952.9 | 2 264.6 | 3 448.7 | 4 429 | 4 711 | 4 592 | 440.9 | 480.7 | 751.0 |
| Гуанз | 3 642.6 | 3 716.6 | 5 699.1 | 4 954 | 4 858 | 5 208 | 735.3 | 765.0 | 1 094.3 |
| Дүн | 21 462.0 | 35 346.6 | 40 181.1 | 23 217 | 23 006 | 25 123 | 924.4 | 1 536.4 | 1 599.4 |

**Зочид буудал.** Зочид буудлын салбарын мэдээнд 2011 онд 281 аж ахуйн нэгж хамрагдсан нь уг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 75.5 хувийг эзэлж байна. Эдгээр аж ахуйн нэгжийн орлого 2011 оны эцэст 48.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 15.6 тэрбум төг буюу 47.3 хувиар нэмэгдэхэд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 13.1 тэрбум төг буюу 69.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого 2011 оны эцэст 9.2 сая төг болж, өмнөх оныхоос 2.6 сая төг буюу 39.2 хувиар өслөө. 3 ба түүнээс дээш одтой буудлын хувьд 9.3 сая төг буюу 57.6 хувь, энгийн буудлынх 446.7 мян.төг буюу 12.6 хувь, 2 одтой буудлынх 366.3 мян.төг буюу 6.4 хувиар өслөө.

Зочид буудлаар үйлчлүүлэгчдийн 66.6 хувь нь Монгол Улсын иргэд, 33.4 хувь нь гадаадын иргэд байна. Нэг зочид буудалд 2011 оны эцэст дунджаар 1494 зочин ногдож, нэг зочин дунджаар 1.6 хоног байрласан байна. Нэг зочинд ногдох орлого 2011 оны эцсийн байдлаар дунджаар 115.6 мян.төг болж, өмнөх оныхоос 33.9 мян.төг буюу 41.4 хувиар өсчээ (Хүснэгт 2).

**Зочид буудлын салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эцэст**

Хүснэгт-III.4

| Үзүүлэлт | Орлого (сая төг) | | | Өрөөний тоо | | | Зочдын тоо | | | Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого (мян.төг) | | | Нэг зочинд ногдох дундаж орлого (мян.төг) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 | 2009 | 2010 | 2011 |
| Энгийн буудал | 12 107.8 | 12 847.2 | 15 337.6 | 3 496 | 3 630 | 3 848 | 272 708 | 287 931 | 266 811 | 3 463.3 | 3 539.2 | 3 985.9 | 44.4 | 44.6 | 57.5 |
| 2 одтой буудал | 802.7 | 1 181.9 | 1 171.9 | 193 | 206 | 192 | 25 586 | 16 172 | 17 236 | 4 159.1 | 5 737.4 | 6 103.6 | 31.4 | 73.1 | 68.0 |
| 3 ба түүнээс дээш одтой буудал | 16 263.8 | 18 914.5 | 32 010.8 | 1 164 | 1 176 | 1 263 | 65 723 | 99 058 | 135 774 | 13 972.3 | 16 083.8 | 25 345.0 | 247.5 | 190.9 | 235.8 |
| Дүн | 29 174.3 | 32 943.6 | 48 520.2 | 4 853 | 5 012 | 5 303 | 364 017 | 403 161 | 419 821 | 6 011.6 | 6 572.9 | 9 149.6 | 80.1 | 81.7 | 115.6 |

## IV. Бусад

### IV.1 Цаг уур, агаарын бохирдол

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 1 дүгээр сард Завхан аймгийн Баянтэс суманд (3.8 мм) орсон баzйна. Энэ оны 1 дүгээр сард Баянхонгор аймгийн Баянцагаан суманд хамгийн их температур 0.0 хэм, Завхан аймгийн Тосонцэнгэл, Отгон суманд хамгийн бага температур -50.0 хэм байлаа. Салхины хурд Өмнөговь аймгийн Булган суманд 20 м/с хүрчээ.

Аймгийн төв, нийслэлд агаарын дундаж хэм 2012 оны 1 дүгээр сард олон жилийн дунджаас 3.4 хэм хүйтэн, өмнөх оны мөн үеийнхээс 1.4 хэм дулаан байлаа.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотын Хархорин захын орчимд 31 удаа, 13-р хороолол, Офицеруудын ордон орчимд тус бүр 26 удаа, 32-ын тойрог орчимд 22 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Хархорин захын орчимд 31 удаа, Офицеруудын ордон, 32-ын тойрог орчимд тус бүр 27 удаа, Баруун дөрвөн замын орчимд 25 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа, Мишээл экспо төвийн орчимд 9 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин захын орчимд 30 удаа, 32-ын тойрог орчимд 23 удаа, 13-р хороолол орчимд 20 удаа, Баруун дөрвөн зам орчимд 19 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 21 удаа, угаарын хий 32-ын тойрог орчимд 3 удаа

агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ (Зураг IV.1, IV.2).

## Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2012 оны 1 дүгээр сард 343 удаа гарсны улмаас 13 хүн амь насаа алдаж, 0.4 мян.толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Энэ оны 1 дүгээр сард объектын түймэр 328 удаа, бичил уурхайн, нурангины осол 3 удаа, гол, нуурын усанд унасан осол 2 удаа, мал, амьтны галзуу өвчин 1 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2011 оны 1 дүгээр сард 0.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Объектын түймрээр 10 хүн, бичил уурхай, нурангины ослоор 2 хүн, усны ослоор 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 14-өөр нэмэгдэж, амь насаа алдсан хүний тоо 1-ээр буурав.

Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын тоо 2011 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 36.3 мянган толгойгоор буурчээ (Хүснэгт IV.1).

Зураг-IV.1

**Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн хоногийн дундаж агууламжийн хамгийн их хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар (мг/м3)**




Зураг-IV.2

**Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламжийн хамгийн их хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар (мг/м3)**




Хүснэгт-IV.1

**Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар***

| Үзүүлэлт | 2010 I | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|---|
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо | 274 | 329 | 343 | 104.3 |
| Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо | 33 | 14 | 13 | 92.9 |
| Шатсан гэр, орон сууцны тоо | 154 | 166 | 180 | 108.4 |
| Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, мян.тол | 1 712.3 | 36.7 | 0.4 | 1.1 |
| Объектын түймрийн тоо | 260 | 312 | 328 | 105.1 |
| Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг | 0.5 | 0.3 | 0.8 | 246.5 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА С.МЭНДСАЙХАН

2012 оны 2 -р сарын 09

Хавсралт № 1

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, бүс, аймаг, нийслэлээр

Хавсралт 1

| Аймаг, нийслэл | Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо | | | Орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагын харьцаа, хувиар | | | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо* | | | Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2010 | 2011 | 2012 | 2010 | 2011 | 2012 | 2010 | 2011 | 2012 | 2010 | 2011 | 2012 |
| **ДҮН** | **36 320** | **38 344** | **58 165** | **195.9** | **158.5** | **188.3** | **1 624** | **1 852** | **2 265** | **2 373** | **3 050** | **3 815** |
| **Баруун бүс** | **7 894** | **7 236** | **6 362** | **183.8** | **142.1** | **159.7** | **118** | **181** | **162** | **255** | **267** | **370** |
| БӨ | 1 207 | 1 150 | 972 | 245.3 | 208.9 | 270.0 | 27 | 25 | 42 | 75 | 45 | 36 |
| ГО | 1 002 | 821 | 799 | 204.2 | 114.2 | 66.2 | 15 | 20 | 27 | 41 | 70 | 47 |
| ЗА | 2 256 | 2 694 | 1 562 | 124.1 | 148.1 | 184.4 | 18 | 24 | 43 | 74 | 67 | 73 |
| УВ | 2 279 | 1 235 | 831 | 381.0 | 182.4 | 166.8 | 36 | 62 | 24 | 45 | 53 | 96 |
| ХО | 1 150 | 1 336 | 2 198 | 103.2 | 84.3 | 124.4 | 22 | 50 | 26 | 20 | 32 | 118 |
| **Хангайн бүс** | **12 594** | **12 591** | **12 015** | **187.9** | **99.9** | **94.6** | **202** | **215** | **298** | **530** | **823** | **710** |
| АР | 1 801 | 2 173 | 2 591 | 313.4 | 145.8 | 211.1 | 27 | 48 | 44 | 48 | 108 | 87 |
| БХ | 3 042 | 2 282 | 1 335 | 154.5 | 111.5 | 81.2 | 29 | 32 | 49 | 100 | 227 | 122 |
| БУ | 778 | 1 690 | 1 159 | 91.6 | 82.4 | 292.6 | 20 | 21 | 23 | 92 | 82 | 122 |
| ОР | 1 950 | 1 811 | 2 400 | 215.4 | 90.9 | 65.7 | 52 | 41 | 74 | 68 | 86 | 102 |
| ӨВ | 2 696 | 2 239 | 2 108 | 131.6 | 47.8 | 92.0 | 26 | 42 | 55 | 49 | 137 | 150 |
| ХӨ | 2 327 | 2 396 | 2 422 | 155.3 | 173.5 | 199.1 | 48 | 31 | 53 | 173 | 183 | 127 |
| **Төвийн бүс** | **5 662** | **6 889** | **6 504** | **225.1** | **244.5** | **110.3** | **257** | **282** | **311** | **321** | **459** | **604** |
| ГС | 199 | 156 | 477 | 45.0 | 35.4 | 73.2 | 10 | 20 | 16 | 17 | 40 | 10 |
| ДА | 1 724 | 1 824 | 1 895 | 126.9 | 166.8 | 250.0 | 54 | 66 | 80 | 65 | 80 | 138 |
| ДО | 549 | 662 | 630 | 121.3 | 224.4 | 139.6 | 53 | 61 | 50 | 76 | 90 | 113 |
| ДУ | 566 | 890 | 688 | 145.5 | 166.5 | 170.9 | 20 | 23 | 26 | 18 | 62 | 85 |
| ӨМ | 498 | 941 | 725 | 467.2 | 739.0 | 109.7 | 15 | 25 | 35 | 21 | 43 | 100 |
| СЭ | 1 120 | 1 018 | 1 139 | 774.5 | 132.2 | 83.2 | 52 | 55 | 68 | 91 | 102 | 108 |
| ТӨ | 1 006 | 1 398 | 950 | 91.9 | 119.2 | 69.4 | 53 | 32 | 36 | 33 | 42 | 50 |
| **Зүүн бүс** | **2 851** | **2 783** | **3 868** | **149.0** | **132.0** | **91.5** | **87** | **100** | **140** | **244** | **316** | **386** |
| ДД | 760 | 802 | 1 858 | 80.4 | 144.4 | 105.9 | 42 | 50 | 49 | 114 | 107 | 187 |
| СҮ | 1 118 | 922 | 879 | 191.5 | 100.5 | 88.9 | 14 | 12 | 24 | 50 | 67 | 80 |
| ХЭ | 973 | 1 059 | 1 131 | 163.6 | 175.4 | 81.4 | 31 | 38 | 67 | 80 | 142 | 119 |
| **Улаанбаатар** | **7 319** | **8 845** | **29 416** | **202.3** | **172.5** | **517.3** | **938** | **1 037** | **1 327** | **1 023** | **1 185** | **1 745** |

* - Төмөр замын цагдаагийн хэлтэс, Иргэний агаарын тээврийн цагдаагийн тасагт бүртгэгдсэн болон Монгол Улсын иргэдийн хилийн чанадад үйлдсэн хэргүүдийг хамруулав.

Хавсралт № 2

**ХАМГИЙН ӨНДӨР, ХАМГИЙН БАГА ҮЗҮҮЛЭЛТТЭЙ АЙМАГ, ХОТ**

| | Хэмжих нэгж | 2012 оны 1 дүгээр сар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улсын дундаж | Хамгийн их | | Хамгийн бага | |
| Хүн амын нягтрал (нэг кв км-т ногдох хүний тоо) | тоо | 1.8 | УБ | 251.0 | ӨМ | 0.3 |
| | | | ОР | 109.9 | ГО | 0.4 |
| | | | ДА | 28.4 | ДУ,ДО,ДД | 0.6 |
| 1000 хүнд ногдох төрөлт | 0/00* | 2.1 | БХ,ОР,ДА | 2.5 | БУ,ТӨ | 1.0 |
| | | | УБ | 2.4 | СЭ | 1.4 |
| | | | ГО,ХӨ | 2.3 | ЗА | 1.5 |
| 1000 хүнд ногдох нас баралт | 0/00* | 0.5 | УВ,ДА | 0.7 | ДУ | 0.3 |
| | | | ӨМ,СҮ,ХӨ,ХЭ | 0.6 | АР,БӨ,ӨВ,СЭ,ТӨ,ГС | 0.4 |
| | | | БХ,БУ,ГО,ДО,ДД | | | |
| | | | ХО,ЗА,УБ,ОР | 0.5 | | |
| Нялхсын нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд) | 0/00* | 17 | СҮ | 55 | ДУ,СЭ,ГС | 0 |
| | | | ӨМ | 42 | ГО | 7 |
| | | | ХЭ | 39 | ДА | 8 |
| 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчид | 0/000** | 13 | ДД | 25 | БӨ | 3 |
| | | | БУ,ӨМ,ДО | 19 | ТӨ | 6 |
| | | | ДУ | 18 | ГС | 7 |
| Орон нутгийн төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100 | % | 188.3 | УБ | 517.3 | ОР | 65.7 |
| | | | БУ | 292.6 | ГО | 66.2 |
| | | | БӨ | 270.0 | ТӨ | 69.4 |

*-промиль
**- продицмиль

Хавсралт № 3

**ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ**

жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

| | ХҮИ, % | | Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012.I / 2011.I | 2012.I / 2011.XII | I зэргийн гурил, кг | | | Хонины мах, кг | | | Үхрийн мах, кг | | | Цагаан будаа, кг | | | Шингэн сүү, л | | |
| | | | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I |
| **Баруун бүс** | | | | | | | | | | | | | | | | | |
| БӨ | **111.2** | **102.7** | 500 | 720 | 540 | 1 700 | 3 500 | 4 500 | 2 000 | 3 500 | 4 600 | 1 300 | 1 500 | 1 700 | 2 000 | 1 600 | 1 500 |
| ГО | **109.9** | **102.4** | 800 | 800 | 900 | 1 500 | 3 000 | 4 000 | 2 300 | 3 500 | 4 800 | 1 400 | 1 700 | 1 700 | 2 000 | 2 200 | 1 800 |
| ЗА | **111.0** | **101.4** | 800 | 760 | 967 | 1 800 | 3 000 | 4 000 | 1 800 | 3 000 | 4 500 | 1 400 | 1 500 | 1 667 | 1 800 | 2 000 | 1 800 |
| УВ | **111.3** | **102.7** | 700 | 800 | 800 | 2 000 | 3 500 | 4 500 | 2 000 | 3 500 | 4 500 | 1 400 | 1 500 | 1 767 | 1 700 | 1 800 | 1 500 |
| ХО | **107.2** | **103.6** | 800 | 850 | 1 100 | 2 000 | 4 200 | 4 500 | 2 300 | 4 300 | 4 500 | 1 300 | 1 500 | 1 700 | 1 800 | 1 500 | 1 600 |
| **Хангайн бүс** | | | | | | | | | | | | | | | | | |
| АР | **109.8** | **102.4** | 600 | 680 | 680 | 1 900 | 3 500 | 4 300 | 2 400 | 4 000 | 4 800 | 1 300 | 1 700 | 1 800 | 1 500 | 1 700 | 1 200 |
| БХ | **110.0** | **103.3** | 720 | 750 | 850 | 2 000 | 3 200 | 3 800 | 2 400 | 3 800 | 4 000 | 1 200 | 1 600 | 1 600 | 1 500 | 1 800 | 1 500 |
| БУ | **111.7** | **102.5** | 560 | 640 | 880 | 2 100 | 3 800 | 4 500 | 2 300 | 4 000 | 5 000 | 1 350 | 1 800 | 1 800 | 1 300 | 1 500 | 1 200 |
| ОР | **107.6** | **102.9** | 550 | 650 | 650 | 2 400 | 3 800 | 4 367 | 2 800 | 4 000 | 4 933 | 1 250 | 1 550 | 1 683 | 1 500 | 1 500 | 1 200 |
| ӨВ | **109.5** | **102.1** | 700 | 800 | 800 | 1 700 | 3 500 | 4 300 | 2 800 | 3 300 | 4 800 | 1 200 | 1 600 | 1 700 | 2 000 | 2 200 | 1 600 |
| ХӨ | **112.0** | **102.2** | 800 | 800 | 800 | 2 500 | 3 800 | 4 500 | 2 500 | 3 800 | 4 500 | 1 450 | 1 800 | 1 900 | 1 200 | 1 800 | 1 500 |
| **Төвийн бүс** | | | | | | | | | | | | | | | | | |
| ГС | **106.7** | **103.5** | 670 | 760 | 850 | 1 800 | 2 900 | 4 000 | 2 400 | 3 200 | 4 200 | 1 200 | 1 750 | 1 700 | 1 000 | 1 500 | 1 800 |
| ДА | **108.1** | **102.4** | 650 | 755 | 820 | 2 450 | 3 750 | 4 600 | 2 850 | 4 500 | 4 700 | 1 250 | 1 750 | 1 700 | 1 500 | 1 300 | 1 250 |
| ДО | **107.2** | **101.4** | 720 | 700 | 700 | 2 300 | 3 500 | 4 200 | 3 430 | 4 800 | 4 800 | 1 200 | 1 500 | 1 550 | 1 730 | 1 800 | 1 800 |
| ДУ | **113.6** | **103.5** | 800 | 820 | 817 | 1 700 | 3 600 | 4 333 | - | - | 3 500 | 1 250 | 1 650 | 1 750 | 2 000 | 1 800 | 2 100 |
| ӨМ | **110.8** | **103.0** | 850 | 800 | 875 | 2 800 | 4 000 | 5 000 | - | - | 3 800 | 1 250 | 1 567 | 1 800 | 2 000 | 2 500 | 2 500 |
| СЭ | **109.0** | **103.2** | 900 | 750 | 600 | 2 400 | 3 500 | 4 500 | 2 500 | 3 800 | 5 200 | 1 300 | 1 700 | 1 700 | 1 100 | 1 200 | 1 000 |
| ТӨ | **110.4** | **102.6** | 560 | 660 | 630 | 2 500 | 3 900 | 4 500 | 3 000 | 5 000 | 6 000 | 1 350 | 1 550 | 1 650 | 1 450 | 1 400 | 1 400 |
| **Зүүн бүс** | | | | | | | | | | | | | | | | | |
| ДД | **109.1** | **103.2** | 640 | 640 | 720 | 2 200 | 3 600 | 4 200 | 2 800 | 4 000 | 5 200 | 1 200 | 1 500 | 1 500 | 1 000 | 1 300 | 1 300 |
| СҮ | **113.5** | **102.5** | 600 | 700 | 820 | 2 200 | 3 500 | 4 000 | 2 800 | 3 800 | 4 500 | 1 200 | 1 500 | 1 500 | 1 500 | 1 500 | 1 500 |
| ХЭ | **107.5** | **102.2** | 700 | 950 | 800 | 2 500 | 3 700 | 4 300 | 3 000 | 5 000 | 5 500 | 1 400 | 1 700 | 1 600 | 1 300 | 1 000 | 1 200 |
| **Улаанбаатар** | | | | | | | | | | | | | | | | | |
| УБ | **110.8** | **102.9** | 664 | 740 | 700 | 2 690 | 4 205 | 4 985 | 3 170 | 4 800 | 5 430 | 1 460 | 1 740 | 1 670 | 1 200 | 1 205 | 1 280 |

Хавсралт № 3-ийн үргэлжлэл

| | ХҮИ, % | | Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2012.I / 2011.I | 2012.I / 2011.XII | Элсэн чихэр, кг | | | Ногоон цай, 2 кг | | | Төмс, кг | | | Сонгино, кг | | |
| | | | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I | 2010.I | 2011.I | 2012.I |
| **Баруун бүс** | | | | | | | | | | | | | | |
| БӨ | **111.2** | **102.7** | 1 600 | 1 800 | 1 733 | 3 500 | 3 650 | 3 800 | 350 | 450 | 500 | 1 000 | 1 000 | 1 000 |
| ГО | **109.9** | **102.4** | 1 600 | 1 700 | 1 700 | 4 500 | 5 500 | 5 500 | 600 | 800 | 600 | 1 000 | 1 500 | 1 200 |
| ЗА | **111.0** | **101.4** | 1 500 | 1 800 | 1 700 | 3 500 | 3 500 | 3 800 | 600 | 800 | 800 | 1 000 | 1 500 | 1 500 |
| УВ | **111.3** | **102.7** | 1 700 | 1 800 | 1 767 | 4 500 | 5 000 | 5 500 | 500 | 600 | 700 | 1 500 | 1 500 | 1 500 |
| ХО | **107.2** | **103.6** | 1 600 | 1 800 | 1 800 | 4 500 | 4 800 | 5 000 | 400 | 500 | 500 | 1 000 | 1 500 | 1 050 |
| **Хангайн бүс** | | | | | | | | | | | | | | |
| АР | **109.8** | **102.4** | 1 500 | 1 800 | 1 800 | 3 250 | 3 300 | 2 500 | 700 | 800 | 800 | 900 | 900 | 1 000 |
| БХ | **110.0** | **103.3** | 1 800 | 1 800 | 1 800 | 4 000 | 4 300 | 4 500 | 800 | 700 | 800 | 1 200 | 1 200 | 1 200 |
| БУ | **111.7** | **102.5** | 1 800 | 1 800 | 1 800 | 3 000 | 3 500 | 3 500 | 500 | 800 | 800 | 1 000 | 1 100 | 1 000 |
| ОР | **107.6** | **102.9** | 1 700 | 1 650 | 1 617 | 3 500 | 5 000 | 5 000 | 400 | 800 | 600 | 1 200 | 1 000 | 1 000 |
| ӨВ | **109.5** | **102.1** | 2 000 | 1 800 | 1 800 | 4 500 | 4 500 | 4 500 | 600 | 800 | 800 | 700 | 800 | 800 |
| ХӨ | **112.0** | **102.2** | 1 800 | 1 700 | 1 800 | 5 000 | 5 200 | 4 800 | 500 | 700 | 700 | 1 500 | 1 500 | 1 300 |
| **Төвийн бүс** | | | | | | | | | | | | | | |
| ГС | **106.7** | **103.5** | 1 400 | 1 650 | 1 700 | 3 000 | 3 000 | 3 000 | 500 | 800 | 900 | 600 | 900 | 883 |
| ДА | **108.1** | **102.4** | 1 850 | 1 750 | 1 700 | 4 500 | 4 500 | 3 800 | 600 | 800 | 700 | 1 200 | 1 000 | 1 000 |
| ДО | **107.2** | **101.4** | 1 870 | 1 533 | 1 550 | 4 200 | 4 500 | 4 500 | 600 | 700 | 733 | 800 | 1 000 | 1 000 |
| ДУ | **113.6** | **103.5** | 1 900 | 1 750 | 1 767 | 4 200 | 3 900 | 3 900 | 700 | 750 | 817 | 800 | 700 | 800 |
| ӨМ | **110.8** | **103.0** | 1 867 | 1 800 | 1 800 | 4 550 | 4 500 | 4 200 | 1 200 | 1 000 | 1 000 | 1 400 | 1 200 | 1 300 |
| СЭ | **109.0** | **103.2** | 1 300 | 1 800 | 1 667 | 3 800 | 4 000 | 5 067 | 500 | 700 | 700 | 1 300 [1] | 1 800 | 1 200 |
| ТӨ | **110.4** | **102.6** | 1 850 | 1 700 | 1 620 | 4 800 | 4 500 | 4 200 | 700 | 800 | 950 | 900 | 850 | 850 |
| **Зүүн бүс** | | | | | | | | | | | | | | |
| ДД | **109.1** | **103.2** | 1 600 | 1 600 | 1 600 | 3 500 | 3 500 | 3 800 | 600 | 700 | 800 | 700 | 1 000 | 1 000 |
| СҮ | **113.5** | **102.5** | 1 800 | 1 700 | 1 570 | 3 600 | 3 500 | 3 700 | 600 | 800 | 870 | 800 | 800 | 780 |
| ХЭ | **107.5** | **102.2** | 1 850 | 1 700 | 1 600 | 3 800 | 5 000 | 4 200 | 700 | 900 | 850 | 800 | 1 000 | 950 |
| **Улаанбаатар** | | | | | | | | | | | | | | |
| УБ | **110.8** | **102.9** | 1 500 | 1 705 | 1 690 | 4 765 | 4 290 | 4 205 | 850 | 955 | 975 | 865 | 980 | 985 |

[1] - Монгол сонгино

Хавсралт № 4

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар

төг

| Аймаг, нийслэл | 1 ширхэгийн дундаж үнэ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Үхрийн шир | | | | | |
| | 2 м-ээс доош урттай | | | 2 м-ээс дээш урттай | | |
| | 2011 I | 2011 XII | 2012 I | 2011 I | 2011 XII | 2012 I |
| | **Баруун бүс** | | | | | |
| БӨ | 11 000 | 21 500 | 22 500 | - | 25 000 | 27 000 |
| ГО | 7 500 | - | - | 10 000 | 27 000 | 28 000 |
| ЗА | 13 000 | 25 000 | 27 800 | 15 000 | 35 000 | 35 000 |
| УВ | 13 000 | 20 000 | 28 000 | 15 000 | 25 000 | 30 000 |
| ХО | 15 000 | - | - | 18 000 | 26 000 | 27 000 |
| | **Хангайн бүс** | | | | | |
| АР | 15 000 | 29 000 | 31 000 | 25 000 | 38 000 | 38 000 |
| БХ | 13 000 | 25 000 | 25 000 | - | 28 000 | 30 000 |
| БУ | 12 000 | 27 500 | 31 000 | 21 000 | 36 000 | 37 500 |
| ОР | 12 500 | 26 500 | 31 000 | 18 000 | 37 500 | 40 000 |
| ӨВ | - | - | - | 12 000 | 25 000 | 30 000 |
| ХӨ | 15 000 | 27 000 | 25 000 | 20 000 | 35 000 | 30 000 |
| | **Төвийн бүс** | | | | | |
| ГС | - | 28 000 | 25 000 | - | 30 000 | 30 000 |
| ДА | 9 500 | 29 000 | 29 000 | 23 000 | 36 000 | 36 000 |
| ДО | - | - | 20 000 | 14 000 | - | 30 000 |
| ДУ | 14 000 | - | - | 18 500 | 29 000 | 28 700 |
| ӨМ | - | - | 20 000 | - | 20 000 | - |
| СЭ | 13 000 | 25 000 | 28 000 | 24 000 | 35 000 | 38 000 |
| ТӨ | 9 000 | 24 000 | 30 000 | 17 500 | 40 000 | 40 000 |
| | **Зүүн бүс** | | | | | |
| ДД | 10 500 | 25 000 | 30 000 | 15 500 | 28 300 | 35 000 |
| СҮ | 13 500 | 25 000 | 30 000 | 20 000 | 35 000 | 36 500 |
| ХЭ | 15 000 | 28 000 | 32 000 | - | - | - |
| | **Улаанбаатар** | | | | | |
| УБ | 15 500 | 30 000 | 35 000 | 26 000 | 40 000 | 41 000 |

Хавсралт № 4-ийн үргэлжлэл

| Аймаг, нийслэл | 1 ширхэгийн дундаж үнэ | | |
|---|---|---|---|
| | Адууны шир | | |
| | 2011 I | 2011 XII | 2012 I |
| | **Баруун бүс** | | |
| БӨ | 18 000 | 41 000 | 43 500 |
| ГО | 20 000 | 39 000 | 40 000 |
| ЗА | 21 500 | 35 000 | 40 000 |
| УВ | 20 000 | 35 000 | 35 000 |
| ХО | 20 000 | 38 000 | 40 000 |
| | **Хангайн бүс** | | |
| АР | 25 000 | 38 000 | 40 000 |
| БХ | 23 000 | 38 000 | 40 000 |
| БУ | 18 500 | 40 500 | 40 500 |
| ОР | 20 000 | 25 000 | 41 000 |
| ӨВ | 26 000 | 38 000 | 40 000 |
| ХӨ | 25 000 | 30 000 | 42 000 |
| | **Төвийн бүс** | | |
| ГС | - | 35 000 | 39 000 |
| ДА | 25 000 | 32 000 | 32 000 |
| ДО | 22 000 | 40 000 | 41 000 |
| ДУ | 25 500 | 43 000 | 42 300 |
| ӨМ | 21 000 | 32 000 | 35 000 |
| СЭ | 20 000 | 31 500 | 32 000 |
| ТӨ | 24 000 | 35 500 | 44 000 |
| | **Зүүн бүс** | | |
| ДД | 20 000 | 38 000 | 42 000 |
| СҮ | 23 000 | 40 000 | 45 000 |
| ХЭ | 25 000 | 43 000 | 45 000 |
| | **Улаанбаатар** | | |
| УБ | 24 000 | 39 000 | 42 000 |

Хавсралт № 4-ийн үргэлжлэл

| Аймаг, нийслэл | 1 кг-ын дундаж үнэ<br>Ямааны ноолуур | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Цагаан | | | Бор | | |
| | 2011 I | 2011 XII | 2012 I | 2011 I | 2011 XII | 2012 I |
| | **Баруун бүс** | | | | | |
| БӨ | - | 48 000 | 50 000 | 40 000 | 48 000 | 50 000 |
| ГО | 45 000 | 45 000 | 45 300 | 45 000 | 45 000 | 45 300 |
| ЗА | 45 000 | 45 000 | 45 000 | - | 45 000 | 45 000 |
| ХО | 45 000 | 50 000 | - | - | 50 000 - | |
| | **Хангайн бүс** | | | | | |
| АР | 40 000 | 45 000 | 55 000 | 40 000 | 45 000 | 55 000 |
| БХ | 48 000 | 45 000 | 45 000 | 48 000 | 40 000 | - |
| ОР | 43 000 | 49 000 | 51 000 | 40 500 | 49 000 | 50 000 |
| ӨВ | 49 000 | 46 000 | 47 000 | 49 000 | 46 000 | 47 000 |
| ХӨ | 48 000 | 45 000 | 53 000 | 50 000 | 42 000 | 52 000 |
| | **Төвийн бүс** | | | | | |
| ГС | 45 000 | - | - | - | - | - |
| ДА | 40 000 | 45 000 | 40 000 | 40 000 | 45 000 | 40 000 |
| ДО | 45 000 | 45 000 | 45 000 | 45 000 | 43 000 | 45 000 |
| ДУ | - | 49 000 | 45 000 | 41 000 | - | - |
| ӨМ | 48 000 | 40 000 | 46 000 | 48 000 | - | 46 000 |
| СЭ | 40 000 | - | - | 40 000 | - | - |
| ТӨ | 44 000 | - | 50 000 | 44 500 | - | 50 000 |
| | **Зүүн бүс** | | | | | |
| СҮ | 42 500 | - | - | - | - | - |
| ХЭ | 35 000 | - | - | - | - | - |
| | **Улаанбаатар** | | | | | |
| УБ | 45 000 | 50 000 | 47 000 | 45 000 | - | - |

Хавсралт № 4-ийн үргэлжлэл

| Аймаг, нийслэл | 1 ширхэгийн дундаж үнэ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хонины /ноостой/ нэхий, ширхэг | | | Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг | | |
| | 2011 I | 2011 XII | 2012 I | 2011 I | 2011 XII | 2012 I |
| | **Баруун бүс** | | | | | |
| БӨ | 6 000 | 14 300 | 14 800 | 17 000 | 20 300 | 21 800 |
| ГО | 8 300 | - | 19 000 | 19 000 | 22 200 | 23 000 |
| ЗА | 5 000 | 18 000 | 19 000 | 18 000 | 19 700 | 21 000 |
| УВ | 6 000 | 13 500 | - | 18 000 | 19 500 | 20 000 |
| ХО | 7 500 | 19 500 | 15 000 | 20 000 | 21 500 | 20 000 |
| | **Хангайн бүс** | | | | | |
| АР | 9 000 | 19 000 | 19 000 | 20 000 | 19 000 | 21 000 |
| БХ | 8 000 | 19 000 | 20 000 | 18 000 | 21 500 | 27 000 |
| БУ | 7 000 | 17 000 | 18 000 | 15 000 | 18 500 | 21 000 |
| ОР | 8 000 | 13 000 | 19 000 | 16 500 | - | - |
| ӨВ | 8 500 | 20 000 | 20 000 | 20 000 | 22 000 | 23 000 |
| ХӨ | 8 000 | 17 000 | 19 000 | 15 000 | - | 21 000 |
| | **Төвийн бүс** | | | | | |
| ГС | 7 500 | 15 000 | 18 500 | 19 000 | 18 000 | 22 000 |
| ДА | 9 000 | 17 000 | 19 000 | - | 21 000 | 23 000 |
| ДО | 8 000 | 18 000 | 19 000 | 17 000 | 20 000 | 22 000 |
| ДУ | 8 500 | 20 000 | 20 000 | 21 000 | 23 700 | 25 000 |
| ӨМ | 7 000 | 16 000 | 19 000 | 17 000 | 22 000 | 24 000 |
| СЭ | 5 000 | - | 18 000 | - | - | 20 000 |
| ТӨ | 7 500 | 16 300 | - | - | 19 000 | 25 000 |
| | **Зүүн бүс** | | | | | |
| ДД | 5 200 | 12 000 | - | 15 800 | 18 000 | 21 300 |
| СҮ | 5 000 | 14 000 | 17 000 | 15 000 | 20 000 | 24 000 |
| ХЭ | 7 000 | 14 000 | 17 000 | 18 000 | 22 000 | 25 000 |
| | **Улаанбаатар** | | | | | |
| УБ | 7 000 | 14 000 | 16 000 | 18 500 | 17 000 | 20 000 |

Хавсралт № 5

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**
(жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, оны үнээр)

сая төг

| | 2011 I | дүнд эзлэх хувь | 2012 I | дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **219 414.9** | **100.0** | **325 846.3** | **100.0** |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 3 155.3 | 1.4 | - | - |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 216 259.7 | 98.6 | 325 846.3 | 100.0 |
| УРСГАЛ ОРЛОГО | 215 845.2 | 98.4 | 324 319.1 | 99.5 |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 201 183.7 | 91.7 | 294 349.3 | 90.3 |
| 1. Орлогын албан татвар | 48 001.4 | 21.9 | 45 387.5 | 13.9 |
| - Аж ахуйн нэгжийн | 22 183.1 | 10.1 | 26 064.5 | 8.0 |
| - Хүн амын | 12 838.7 | 5.9 | 19 323.0 | 5.9 |
| - Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн | 12 979.5 | 5.9 | - | - |
| 2. Нийгмийн даатгалын шимтгэл | 23 493.4 | 10.7 | 40 603.1 | 12.5 |
| 3. Өмчийн татвар | 843.2 | 0.4 | 1 345.5 | 0.4 |
| 4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар | 90 404.0 | 41.2 | 71 687.6 | 22.0 |
| - Нэмэгдсэн өртгийн татвар | 70 369.8 | 32.1 | 50 440.1 | 15.5 |
| - Онцгой албан татвар | 19 350.5 | 8.8 | 19 850.7 | 6.1 |
| - Тусгай зориулалтын орлого | 683.7 | 0.3 | 1 396.8 | 0.4 |
| 5. Гадаад худалдааны татварын орлого | 18 224.6 | 8.3 | 70 029.2 | 21.5 |
| 6. Бусад татвар | 20 217.0 | 9.2 | 65 296.4 | 20.0 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14 661.6 | 6.7 | 29 969.8 | 9.2 |
| ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 414.4 | 0.2 | 493.2 | 0.2 |
| ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | - | - | 1 034.0 | 0.3 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **246 558.3** | **100.0** | **260 030.8** | **100.0** |
| НИЙТ ЗАРЛАГА | 241 478.5 | 97.9 | 264 414.1 | 101.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 228 105.3 | 92.5 | 257 164.1 | 98.9 |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 93 447.0 | 37.9 | 101 702.7 | 39.1 |
| - Цалин, хөлс | 65 126.6 | 26.4 | 61 274.3 | 23.6 |
| - Бараа, үйлчилгээний бусад зардал | 28 320.4 | 11.5 | 40 428.4 | 15.5 |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | 9 558.2 | 3.9 | 11 020.0 | 4.2 |
| 3. Татаас ба шилжүүлэг | 125 100.1 | 50.7 | 144 441.3 | 55.5 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 13 373.1 | 5.4 | 7 250.1 | 2.8 |
| Дотоод эх үүсвэр | 12 202.6 | 4.9 | 2 235.2 | 0.9 |
| - Хөрөнгө оруулалт | 10 154.7 | 4.1 | 1 915.1 | 0.7 |
| - Их засварын зардал | - | - | 184.1 | 0.1 |
| - Улсын нөөц бүрдүүлэх зардал | 2 047.9 | 0.8 | 136.1 | 0.1 |
| Гадаад эх үүсвэр | 1 170.6 | 0.5 | 5 014.8 | 1.9 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ | 5 079.8 | 2.1 | -4 383.3 | - 1.7 |
| - Гадаад зээлээр санхүүжих төсөл | - | - | 88.2 | 0.0 |

Хавсралт № 6

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

(жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, оны үнээр)

сая төг

| Аймаг, нийслэл | Орлого | | | Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг | | Зарлага | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % | 2011 I | 2012 I | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
| **Бүгд** | **26 631.7** | **35 579.6** | **133.6** | **3 165.6** | **4 780.8** | **16 797.3** | **18 893.4** | **112.5** |
| | | | **Баруун бүс** | | | | | |
| **Дүн** | **2 545.7** | **2 642.9** | **103.8** | **1 660.8** | **1 612.0** | **1 791.9** | **1 655.1** | **92.4** |
| БӨ | 424.5 | 467.2 | 110.0 | 250.0 | 300.0 | 203.2 | 173.0 | 85.2 |
| ГО | 370.4 | 171.4 | 46.3 | 111.1 | - | 324.4 | 258.9 | 79.8 |
| ЗА | 690.5 | 817.6 | 118.4 | 499.4 | 612.0 | 466.4 | 443.5 | 95.1 |
| УВ | 720.5 | 852.0 | 118.2 | 617.3 | 700.0 | 395.0 | 510.6 | 129.3 |
| ХО | 339.7 | 334.7 | 98.5 | 183.0 | - | 402.8 | 269.1 | 66.8 |
| | | | **Хангайн бүс** | | | | | |
| **Дүн** | **4 520.7** | **6 787.7** | **150.1** | **1 121.7** | **2 494.2** | **4 525.6** | **7 177.4** | **158.6** |
| АР | 556.3 | 654.2 | 117.6 | 381.7 | 450.0 | 381.6 | 310.0 | 81.2 |
| БХ | 536.3 | 811.6 | 151.3 | 350.0 | 600.0 | 480.8 | 999.7 | 207.9 |
| БУ | 290.8 | 1 058.2 | 363.9 | - | 554.2 | 353.1 | 361.6 | 102.4 |
| ОР | 2 319.9 | 2 889.4 | 124.5 | - | - | 2 551.7 | 4 397.5 | 172.3 |
| ӨВ | 189.3 | 715.8 | 378.1 | - | 500.0 | 396.4 | 778.0 | 196.2 |
| ХӨ | 628.0 | 658.5 | 104.9 | 390.0 | 390.0 | 362.0 | 330.7 | 91.4 |
| | | | **Төвийн бүс** | | | | | |
| **Дүн** | **6 658.2** | **5 962.2** | **89.5** | **383.1** | **674.6** | **2 722.9** | **5 404.9** | **198.5** |
| ГС | 117.6 | 280.9 | 238.8 | 33.1 | 112.6 | 332.1 | 383.6 | 115.5 |
| ДА | 618.6 | 748.5 | 121.0 | - | - | 371.0 | 299.4 | 80.7 |
| ДО | 680.8 | 649.9 | 95.5 | - | - | 303.4 | 465.4 | 153.4 |
| ДУ | 609.7 | 619.1 | 101.5 | 350.0 | 500.0 | 366.2 | 362.3 | 98.9 |
| ӨМ | 3 525.7 | 2 286.5 | 64.9 | - | - | 477.1 | 2 084.5 | 436.9 |
| СЭ | 661.2 | 731.7 | 110.7 | - | - | 500.2 | 879.4 | 175.8 |
| ТӨ | 444.6 | 645.6 | 145.2 | - | 62.0 | 373.1 | 930.3 | 249.4 |
| | | | **Зүүн бүс** | | | | | |
| **Дүн** | **1 536.0** | **838.0** | **54.6** | **-** | **-** | **1 163.3** | **915.6** | **78.7** |
| ДД | 448.9 | 337.2 | 75.1 | - | - | 310.9 | 318.5 | 102.4 |
| СҮ | 547.3 | 172.8 | 31.6 | - | - | 544.7 | 194.4 | 35.7 |
| ХЭ | 539.7 | 328.0 | 60.8 | - | - | 307.7 | 402.8 | 130.9 |
| | | | **Улаанбаатар** | | | | | |
| **Дүн** | **11 371.1** | **19 348.8** | **170.2** | **-** | **-** | **6 593.5** | **3 740.3** | **56.7** |
| УБ | 11 371.1 | 19 348.8 | 170.2 | - | - | 6 593.5 | 3 740.3 | 56.7 |

Хавсралт № 7

## ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО

(жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, оны үнээр)

сая төг

| Аймаг, нийслэл | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|
| **Бүгд** | **3 796.0** | **5 750.0** | **151.5** |
| ОР | 2 200.0 | 4 000.0 | 181.8 |
| ДА | 96.0 | - | - |
| ӨМ | - | 1 500.0 | - |
| СЭ | - | 250.0 | - |
| УБ | 1 500.0 | - | - |

Хавсралт № 8

**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр**

сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2010 I | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **142 558.3** | **146 467.5** | **154 756.5** | **105.7** |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | **77 131.2** | **79 875.6** | **86 146.6** | **107.9** |
| Нүүрс олборлолт | 12 484.6 | 16 630.5 | 15 930.6 | 95.8 |
| Газрын тос олборлолт | 11 914.8 | 9 683.3 | 16 868.6 | 174.2 |
| Металлын хүдэр олборлолт | 50 971.1 | 51 745.4 | 51 411.0 | 99.4 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 1 760.6 | 1 816.4 | 1 936.4 | 106.6 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **41 733.9** | **41 691.9** | **42 170.6** | **101.1** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 26 811.0 | 26 933.3 | 27 353.7 | 101.6 |
| Тамхи үйлдвэрлэл | 81.2 | 2 175.8 | 1 313.0 | 60.3 |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 4 501.8 | 4 825.9 | 4 135.3 | 85.7 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 626.4 | 748.3 | 517.6 | 69.2 |
| Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 47.1 | 38.7 | 106.1 | 274.3 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 133.3 | 179.3 | 148.0 | 82.5 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 173.3 | 162.1 | 245.2 | 151.3 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 919.9 | 710.2 | 772.3 | 108.7 |
| Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл | 54.1 | 26.1 | 300.1 | 1 148.0 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 1 341.4 | 1 282.9 | 1 952.9 | 152.2 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 5.5 | 118.3 | 160.7 | 135.8 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 316.6 | 259.0 | 810.1 | 312.8 |
| Төмрийн үйлдвэрлэл | 6 608.9 | 3 918.0 | 3 534.0 | 90.2 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 1.5 | 0.9 | 1.3 | 137.0 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 13.9 | 124.3 | 594.4 | 478.2 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 39.6 | 90.2 | 149.8 | 166.2 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл | 0.6 | 0.9 | 0.4 | 40.0 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 57.8 | 97.9 | 75.8 | 77.4 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж** | **23 693.2** | **24 900.0** | **26 439.3** | **106.2** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 22 489.1 | 23 695.0 | 25 243.8 | 106.5 |
| Ус ариутгал, усан хангамж | 1 204.1 | 1 205.0 | 1 195.5 | 99.2 |

Хавсралт № 9

**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2010 I | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|---|---|
| Цахилгаан эрчим хүч | сая кВт.цаг | 346.1 | 379.9 | 409.1 | 107.7 |
| Дулааны эрчим хүч | мян.Гкал | 1 326.7 | 1 295.4 | 1 350.8 | 104.3 |
| Газрын тос | мян.баррел | 217.8 | 177.0 | 308.3 | 174.2 |
| Нүүрс | мян.т | 1 191.6 | 1 587.3 | 1 520.5 | 95.8 |
| Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр | мян.т | 29.7 | 28.7 | 29.5 | 102.8 |
| Молибдений баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлснээр | т | 424.0 | 347.3 | 404.8 | 116.6 |
| Хайлуур жоншны баяжмал | мян.т | 10.7 | 9.5 | 11.2 | 117.9 |
| Алт | кг | 299.8 | 467.1 | 316.0 | 67.7 |
| Катодын зэс, 99% | т | 244.7 | 205.3 | 196.6 | 95.8 |
| Сүлжмэл эдлэл | мян.ш | 38.6 | 55.8 | 45.0 | 80.6 |
| Самнасан ноолуур | т | 19.5 | 4.3 | 7.2 | 167.4 |
| Хивс | мян.$м^2$ | 56.0 | 70.0 | 84.9 | 121.3 |
| Тэмээний ноосон хөнжил | мян.м | 1.2 | 2.4 | 1.7 | 70.8 |
| Зүсмэл материал | $м^3$ | 375.7 | 203.8 | 290.4 | 142.5 |
| Шохой | мян.т | 4.8 | 3.1 | 4.0 | 127.1 |
| Сонин | сая х.д.х | 3.0 | 3.0 | 4.3 | 144.5 |
| Малын мах | т | 1 187.8 | 388.6 | 1 159.5 | 298.4 |
| Хиамны зүйл | т | 98.6 | 184.6 | 137.9 | 74.7 |
| Гурил | т | 22 751.0 | 15 995.3 | 8 192.8 | 51.2 |
| Талх | т | 1 829.6 | 1 610.2 | 2 229.7 | 138.5 |
| Нарийн боов | т | 1 309.8 | 1 411.1 | 1 481.5 | 105.0 |
| Гоймон | т | 725.5 | 92.4 | 260.8 | 282.3 |
| Амтат ус, ундаа | мян.л | 2 304.8 | 2 243.2 | 3 532.9 | 157.5 |
| Архи, дарс | мян.л | 1 886.6 | 2 783.8 | 2 648.5 | 95.1 |
| Спирт | мян.л | 449.9 | 565.1 | 380.6 | 67.4 |

Хавсралт № 10

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**

сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2010 I | 2011 I | 2012 I | Үүнээс: гадаадад | Дундэзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2010 I | 2011 I | 2012 I |
| **Аж үйлдвэр бүгд** | **281 946.4** | **291 545.1** | **355 424.8** | **183 659.6** | **100.0** | **100.0** | **100.0** |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | **185 256.0** | **175 946.3** | **202 923.5** | **172 056.6** | **65.7** | **60.4** | **57.1** |
| Нүүрс олборлолт | 38 614.1 | 40 721.7 | 50 812.3 | 33 712.9 | 13.7 | 14.0 | 14.3 |
| Газрын тос олборлолт | 21 418.6 | 16 358.9 | 30 036.2 | 30 036.2 | 7.6 | 5.6 | 8.5 |
| Металлын хүдэр олборлолт | 121 478.6 | 115 199.5 | 117 457.4 | 103 770.8 | 43.1 | 39.5 | 33.0 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 3 744.7 | 3 666.1 | 4 617.6 | 4 536.7 | 1.3 | 1.3 | 1.3 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **62 328.1** | **76 500.8** | **105 593.1** | **11 603.0** | **22.1** | **26.2** | **29.7** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт | 39 526.3 | 53 040.7 | 70 297.0 | 317.0 | 14.0 | 18.2 | 19.8 |
| Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт | 2 406.6 | 4 587.2 | 4 070.8 | 231.4 | 6.1 * | 8.6 * | 5.8 * |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 2 041.6 | 2 595.7 | 2 474.8 | - | 5.2 * | 4.9 * | 3.5 * |
| Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл | 14 985.0 | 9 669.8 | 5 046.0 | - | 37.9 * | 18.2 * | 7.2 * |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 5 502.8 | 6 105.6 | 6 909.2 | - | 13.9 * | 11.5 * | 9.8 * |
| Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа орood/ | 14 590.3 | 30 082.3 | 51 796.2 | 85.5 | 36.9 * | 56.7 * | 73.7 * |
| Тамхи үйлдвэрлэл | 2 011.4 | 3 500.0 | 3 414.0 | - | 0.7 | 1.2 | 1.0 |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 5 409.3 | 7 059.7 | 5 144.1 | 772.3 | 1.9 | 2.4 | 1.4 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 757.2 | 973.6 | 1 078.6 | - | 0.3 | 0.3 | 0.3 |
| Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 98.3 | 60.9 | 86.0 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 322.8 | 599.2 | 628.6 | - | 0.1 | 0.2 | 0.2 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 1 093.7 | 984.3 | 1 372.1 | - | 0.4 | 0.3 | 0.4 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 904.1 | 1 089.7 | 772.0 | - | 0.3 | 0.4 | 0.2 |
| Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл | 25.9 | 23.1 | 4 382.3 | 3 969.7 | 0.0 | 0.0 | 1.2 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 1 302.4 | 2 270.6 | 3 116.1 | - | 0.5 | 0.8 | 0.9 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 6.5 | 6.4 | 128.5 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 1 419.2 | 846.5 | 2 144.0 | - | 0.5 | 0.3 | 0.6 |
| Төмрийн үйлдвэрлэл | 8 999.5 | 5 473.0 | 10 205.2 | 6 502.9 | 3.2 | 1.9 | 2.9 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 192.2 | 112.4 | 1 717.0 | 41.1 | 0.1 | 0.0 | 0.5 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 9.0 | 118.7 | 781.0 | - | 0.0 | 0.0 | 0.2 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | - | 9.5 | - | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл | 73.0 | 31.8 | 9.7 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл | 120.7 | 252.2 | 220.0 | - | 0.0 | 0.1 | 0.1 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 56.5 | 48.6 | 96.8 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж** | **34 362.4** | **39 098.1** | **46 908.3** | **-** | **12.2** | **13.4** | **13.2** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 31 612.9 | 35 720.2 | 43 086.8 | - | 11.2 | 12.3 | 12.1 |
| Ус ариутгал, усан хангамж | 2 749.4 | 3 377.9 | 3 821.5 | - | 1.0 | 1.1 | 1.1 |

Тайлбар: * Бүлгийн дундэзлэх хувь

Хавсралт № 11

## Гадаад худалдааны нийт эргэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

мян.ам.долл

| Үзүүлэлт | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|
| **Нийт бараа эргэлт** | **556 771.8** | **735 180.4** | **132.0** |
| **Экспорт** | **208 594.1** | **240 287.1** | **115.2** |
| Валютын төлбөртэй худалдаа | 208 592.3 | 240 196.5 | 115.2 |
| Бараа солилцоо | - | - | - |
| Гадаадын захиалагчийн материалаар хийсэн бараа | 1.8 | 90.5 | 5 025.0 |
| Бусад | - | 0.2 | - |
| **Импорт** | **348 177.7** | **494 893.2** | **142.1** |
| Валютын төлбөртэй худалдаа | 297 672.8 | 411 745.9 | 138.3 |
| Бараа солилцоо | 32.0 | - | - |
| Гадаадын тусламжийн бараа | 8 402.5 | 13 746.9 | 163.6 |
| Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа | 41 678.6 | 69 032.4 | 165.6 |
| Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа | 377.0 | 310.7 | 82.4 |
| Гадаадын захиалагчийн материал, эд зүйлс | 14.1 | 57.4 | 406.7 |
| Бусад | 0.6 | - | - |

Хавсралт № 12

## Экспорт, импорт, барааны бүлгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

мян.ам.долл

| Барааны бүлэг | 2011 I | | 2012 I | |
|---|---|---|---|---|
| | Дүн | Дүнд эзлэх хувь | Дүн | Дүнд эзлэх хувь |
| **Экспорт** | **208 594.1** | **100.0** | **240 287.1** | **100.0** |
| Эрдэс бүтээгдэхүүн | 190 067.0 | 91.1 | 218 145.5 | 90.8 |
| Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос | 2 723.0 | 1.3 | 6 987.5 | 2.9 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 2 866.5 | 1.4 | 4 241.1 | 1.8 |
| Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги | 873.5 | 0.4 | 3 732.3 | 1.6 |
| Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн | 4 479.7 | 2.1 | 2 008.6 | 0.8 |
| Мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 2 209.3 | 1.1 | 1 797.9 | 0.7 |
| Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 1 838.8 | 0.9 | 1 636.5 | 0.7 |
| Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 1 846.0 | 0.9 | 865.9 | 0.4 |
| Бусад | 1 690.3 | 0.8 | 871.9 | 0.3 |
| **Импорт** | **348 177.7** | **100.0** | **494 893.2** | **100.0** |
| Эрдэс бүтээгдэхүүн | 67 878.2 | 19.5 | 147 619.7 | 29.8 |
| Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги | 85 368.4 | 24.5 | 108 628.9 | 21.9 |
| Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг | 92 712.1 | 26.6 | 99 846.9 | 20.2 |
| Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 17 633.2 | 5.1 | 26 017.9 | 5.3 |
| Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 21 216.8 | 6.1 | 25 668.2 | 5.2 |
| Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн | 12 171.6 | 3.5 | 17 684.4 | 3.6 |
| Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл | 12 233.7 | 3.5 | 14 084.8 | 2.8 |
| Хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр,хяналт,эмнэлэг,мэс заслын багаж,цаг, хөгжмийн зэмсэг | 5 809.0 | 1.7 | 12 625.6 | 2.6 |
| Үйлдвэрийн төрөл бүрийн  бараа | 5 077.4 | 1.5 | 8 974.3 | 1.8 |
| Бусад | 28 077.2 | 8.0 | 33 742.5 | 6.8 |

Хавсралт № 13

**Төмөр зам, агаарын тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**

| Тээврийн төрөл, үзүүлэлтүүд | 2010 I | 2011 I | 2012 I | 2012 I / 2011 I % |
|---|---|---|---|---|
| **I. Төмөр замын тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа, мян.т | 1 277.8 | 1 345.0 | 1 733.8 | 128.9 |
| дотоодын | 769.6 | 764.5 | 793.8 | 103.8 |
| гаргалт | 272.8 | 305.1 | 630.4 | 206.6 |
| оруулалт | 72.7 | 114.1 | 197.3 | 172.9 |
| дамжин өнгөрөх | 162.7 | 161.4 | 112.3 | 69.6 |
| Ачаа эргэлт, сая т.км | 690.2 | 709.4 | 1 063.7 | 150.0 |
| дотоодын | 219.8 | 222.4 | 265.7 | 119.5 |
| гаргалт | 253.0 | 246.1 | 570.6 | 231.9 |
| оруулалт | 36.7 | 61.8 | 102.8 | 166.4 |
| дамжин өнгөрөх | 180.6 | 179.2 | 124.6 | 69.6 |
| Зорчигчдын тоо, мян.хүн | 257.9 | 293.0 | 293.7 | 100.3 |
| олон улсад зорчсон | 9.1 | 10.6 | 12.7 | 119.6 |
| дотоодод зорчсон | 248.8 | 282.4 | 281.1 | 99.5 |
| Зорчигч эргэлт, сая хүн км | 91.5 | 103.6 | 107.3 | 103.6 |
| Шилжүүлсэн сая т.км | 781.7 | 813.0 | 1 171.0 | 144.0 |
| Тээврийн орлого, оны үнээр, сая төг | 19 860.5 | 24 937.1 | 32 900.5 | 131.9 |
| **II. Агаарын тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа, т | 138.5 | 128.6 | 302.3 | 235.0 |
| шуудан | 33.7 | 34.3 | 29.3 | 85.4 |
| тээш | 21.4 | 23.0 | 30.9 | 134.3 |
| ачаа | 83.4 | 71.3 | 242.1 | 339.5 |
| Ачаа эргэлт, мян.т.км | 261.8 | 251.9 | 797.8 | 316.7 |
| шуудан | 55.6 | 58.5 | 55.4 | 94.7 |
| тээш | 31.4 | 38.2 | 48.1 | 126.1 |
| ачаа | 174.9 | 155.2 | 694.3 | 447.3 |
| Зорчигчдын тоо, мян.хүн | 24.1 | 36.5 | 46.2 | 126.5 |
| олон улсад зорчсон | 18.3 | 25.3 | 30.0 | 118.6 |
| дотоодод зорчсон | 5.8 | 11.2 | 16.2 | 144.2 |
| Зорчигч эргэлт, сая хүн км | 38.7 | 59.0 | 79.5 | 134.8 |
| Шилжүүлсэн сая т.км | 3.8 | 5.6 | 8.0 | 142.9 |
| Тээврийн орлого, оны үнээр, сая төг | 6 759.1 | 9 021.4 | 11 564.5 | 128.2 |

## Гадаад худалдааны төлөв байдал

### Оршил

Гадаад худалдааг үр ашигтай эрхлэх нь улс орны эдийн засгийн байдлыг тогтворжуулах, төлбөрийн тэнцлийг сайжруулах болон валютын нөөцийг арвижуулахад чухал ач холбогдолтой.

Манай улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллагын 134 дэх жинхэнэ гишүүн орон болсноор гадаад худалдааны үйл ажиллагаанд шинэ орчин бий болсон. Дэлхийн худалдааны байгууллага нь дэлхийн улс үндэстнүүдийн хоорондын худалдааны дэг журмыг зохицуулдаг байгууллага бөгөөд уг байгууллагад элсэн орсноор манай орон энэ байгууллагын гишүүн орнуудын зүгээс нэн тааламжтай нөхцөл эдлэх, хөрш зэргэлдээ орнуудын зүгээс гаалийн татвараар манай гадаад худалдаанд тавьсан хүндрэлийг хөнгөвчлүүлэх талаар хэлэлцэн тохиролцох аятай боломж бүрдсэн.

Экспорт, импортын хэмжээ, тэдгээрийн бүтэц нь тухайн улс орны хөгжлийн түвшинг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг юм. Экспорт, импортын бүтцийг улс орнуудын түвшинд авч үзэхэд буурай хөгжилтэй орнуудын экспортын дийлэнхийг анхдагч бүтээгдэхүүн эзэлж, харин өндөр хөгжилтэй орнуудын хувьд аж үйлдвэрийн боловсруулалт хийсэн эцсийн бүтээгдэхүүн эзэлж байна.

ҮСХ-ны дарга, Сангийн сайд болон ГЕГ-ын даргын 2009 оны 02-р сарын 17-ны өдрийн хамтран баталсан "Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ын дагуу гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэлд үндэслэн Үндэсний статистикийн хороо нь гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг сар, улирал, жилээр нэгтгэн хэрэглэгчдэд тархааж байна.

### Гадаад худалдааны тэнцэл, экспорт, импортын бүтэц

Гадаад худалдааны нийт эргэлт 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11307.2 сая ам. доллар, үүнээс экспорт 4780.4 сая ам.доллар, импорт 6526.9 сая ам.доллар боллоо. Гадаад худалдааны тэнцэл 2011 онд 1746.5 сая ам.долларын алдагдалтай гарав. Нийт эргэлт 2010 оныхоос 1.8 дахин нэмэгдсэний дотор экспорт 1.6 дахин, импорт 2.0 дахин нэмэгдсэн байна.

Манай улсын гадаад худалдааны тэнцэл зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойших 1993, 1994, 1995, 1997, 2006 онуудад ашигтай, бусад онд алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ буурахгүй байна.

*Хүснэгт 1*

**Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд**

*сая ам.долл*

| Он | Нийт эргэлт | Экспорт | Импорт | Тэнцэл (+,-) | Нийт эргэлтэд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Экспорт | Импорт |
| 1989 | 1 684.5 | 721.5 | 963.0 | -241.5 | 42.8 | 57.2 |
| 1990 | 1 584.7 | 660.7 | 924.0 | -263.3 | 41.7 | 58.3 |
| 1991 | 708.9 | 348.0 | 360.9 | -12.9 | 49.1 | 50.9 |
| 1992 | 806.7 | 388.4 | 418.3 | -29.9 | 48.1 | 51.9 |
| 1993 | 761.6 | 382.6 | 379.0 | 3.6 | 50.2 | 49.8 |
| 1994 | 614.5 | 356.1 | 258.4 | 97.7 | 57.9 | 42.1 |
| 1995 | 888.6 | 473.3 | 415.3 | 58.0 | 53.3 | 46.7 |
| 1996 | 875.2 | 424.3 | 450.9 | -26.6 | 48.5 | 51.5 |
| 1997 | 1 036.8 | 568.5 | 468.3 | 100.3 | 54.8 | 45.2 |
| 1998 | 965.6 | 462.3 | 503.3 | -40.9 | 47.9 | 52.1 |
| 1999 | 967.0 | 454.2 | 512.8 | -58.6 | 47.0 | 53.0 |
| 2000 | 1 150.3 | 535.8 | 614.5 | -78.7 | 46.6 | 53.4 |

| Он | Нийт эргэлт | Экспорт | Импорт | Тэнцэл (+,-) | Нийт эргэлтэд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Экспорт | Импорт |
| 2001 | 1 233.9 | 596.2 | 637.7 | -41.5 | 48.3 | 51.7 |
| 2002 | 1 214.4 | 524.0 | 690.4 | -166.4 | 43.1 | 56.8 |
| 2003 | 1 406.3 | 615.4 | 790.9 | -175.5 | 43.8 | 56.2 |
| 2004 | 1 888.4 | 869.1 | 1 019.3 | -150.2 | 46.0 | 54.0 |
| 2005 | 2 241.2 | 1 063.9 | 1 177.3 | -113.4 | 47.5 | 52.5 |
| 2006 | 2 977.0 | 1 542.0 | 1 435.0 | 107.0 | 51.8 | 48.2 |
| 2007 | 4 009.3 | 1 947.5 | 2 061.8 | -114.3 | 48.6 | 51.4 |
| 2008 | 5 779.0 | 2 534.5 | 3 244.5 | -710.0 | 43.9 | 56.1 |
| 2009 | 4 023.1 | 1 885.4 | 2 137.7 | -252.3 | 46.9 | 53.1 |
| 2010 | 6 108.6 | 2 908.5 | 3 200.1 | -291.6 | 47.6 | 52.4 |
| 2011* | 11 307.2 | 4 780.4 | 6 526.9 | -1 746.5 | 42.3 | 57.7 |

**-Урьдчилсан гүйцэтгэл*

Алдагдлын хэмжээ буурахгүй байгаа нь хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд: Нэгдүгээрт, 1997, 2001, 2003-2006, 2010 онд манай улсын экспортын өсөлтийн хурд импортынхоос илүү байсан хэдий ч гадаад худалдааны нийт эргэлтийн 50-иас илүү хувийг импортын худалдаа эзэлж байгаагаас үүдэн гадаад худалдааны алдагдал буурахгүй байна.

Манай улсын эдийн засгийн өсөлт хадгалагдаж, дотоодод бизнесийн орчин идэвхжиж, ялангуяа олборлох, боловсруулах салбарын үйлдвэрлэл, барилга угсралтын ажлын гүйцэтгэл нэмэгдсэнтэй холбогдож энэ чиглэлээр импортоор орж ирж буй материал, машин, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ өссөн нь алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

*Зураг 1.*

**Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд, сая ам.доллараар**



Хоёрдугаарт, 2006-2008 оныг эс тооцвол экспортод гаргаж байгаа барааны дундаж үнийн өсөлт импортоор оруулж ирж байгаа барааныхаас байнга доогуур байсан нь гадаад худалдааны алдагдал өсөх үндсэн шалтгаан болсон гэж дүгнэхэд хүргэж байна.

*Хүснэгт 2*

**Экспорт, импортын барааны үнийн дундаж индекс, худалдааны нөхцлийн индекс**

*2005=100*

| | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Экспортын үнийн индекс | 71.1 | 62.1 | 59.6 | 67.8 | 84.7 | 100.0 | 137.4 | 171.4 | 202.0 | 210.3 | 275.4 |
| Импортын үнийн индекс | 86.0 | 90.3 | 79.3 | 95.0 | 102.8 | 100.0 | 118.9 | 159.2 | 190.5 | 180.3 | 246.1 |
| Худалдааны нөхцлийн индекс | 82.7 | 68.8 | 75.2 | 71.4 | 82.4 | 100.0 | 115.6 | 107.7 | 106.0 | 116.6 | 111.9 |

Гадаад худалдааны үр ашгийг харуулах худалдааны нөхцлийн индекс нь экспортын дундаж үнийн индексийг импортын дундаж үнийн индекст харьцуулсан харьцаагаар тодорхойлогдох бөгөөд 100-аас дээш гарвал худалдааны нөхцлийг таатай байна гэж үздэг. Манай орны хувьд энэ үзүүлэлт 2006 оноос хойш 100-аас их гарч байгаа ба 2010 онд 111.9 байгаа нь манай гадаад худалдааны байдал тааламжтай байгааг харуулж байна.

Манай улсын экспортын орлого цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний орлогоос шалтгаалж байдаг бол тэдгээр гол нэр төрлийн бүтээгдэхүүний орлого нь дэлхийн зах зээлийн үнээс шууд хамааралтай байдаг.

Гуравдугаарт, гадаад худалдааны алдагдлын шалтгаан нь манай орны экспорт, импортын барааны бүтэцтэй холбоотой байна. Манай улсын экспортод эрдэс бүтээгдэхүүн, үнэт металл, нэхмэл бүтээгдэхүүн, мал аж ахуйн түүхий эд зонхилж, импортын бараанд нефтийн бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн өндөр хувийг эзэлж байна. Дэлхийн зах зээлд эцсийн бүтээгдэхүүний үнэ түүхий эдийнхээс илүү хурдацтай өсч ирсэн билээ. Эдийн засгийн хөгжлийн сул байдлаас шалтгаалж, манай улсын экспортын ихэнхийг түүхий буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

*Хүснэгт 3*

**Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, хувиар**

| | 2000 | 2005 | 2008 | 2009 | 2010 | 2011* |
|---|---|---|---|---|---|---|
| Эрдэс бүтээгдэхүүн | 35.2 | 42.7 | 60.3 | 66.4 | 81.0 | 89.2 |
| Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 14.1 | 31.2 | 23.7 | 16.4 | 6.1 | 2.4 |
| Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 35.9 | 18.0 | 8.9 | 10.2 | 7.4 | 5.0 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 7.9 | 2.9 | 1.6 | 1.5 | 1.1 | 1.1 |
| Бусад | 6.9 | 5.2 | 5.4 | 5.5 | 4.4 | 2.3 |

**-Урьдчилсан гүйцэтгэл*

Дээрх хүснэгтээс харахад экспортын бүтцэд нэлээд өөрчлөлт гарч байна. Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2000 онд 35.2 хувь, 2005 онд 42.7 хувь, 2010 онд 81.0 хувь, 2011 онд 89.2 хувьд хүрч өссөн байна. Нийт экспортод үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс 2000 онд 14.1 хувь, 2005 онд 31.2 хувь, 2010 онд 6.1 хувь, 2011 онд 2.4 хувь болж буурчээ.

Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл 2000 онд 7.9 хувь, 2005 онд 2.9 хувь, 2010 онд 1.1 хувь, 2011 онд 1.1 хувь болж, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн 2000 онд 35.9 хувь, 2005 онд 18.0 хувь, 2010 онд 7.4 хувь, 2010 онд 5.0 хувь болж буурсан байна.

Нийт экспортод 2005-2011 онд эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь 46.5 пунктээр нэмэгдсэн бол үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн бүлгийн эзлэх хувь 28.8 пункт, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний бүлгийнх 13.0 пункт, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн бүлгийнх 1.8 пунктээр буурсан байна. Энэ нь эрдэс бүтээгдэхүүнд өндөр хувь эзэлдэг зэсийн баяжмалын биет хэмжээ 2011 онд 2005 оныхоос 2.4 хувиар буурсан хэдий ч нэг тонн зэсийн баяжмалын үнэ дунджаар 3.0 дахин өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Түүнчлэн экспортод гаргасан боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны биет хэмжээ 2011 онд 2005 оныхоос 88.8 хувиар буурснаас шалтгаалан үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн бүлгийн нийт экспортод эзлэх хувь буурсан байна. Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүнд өндөр хувь эзэлдэг самнасан ноолуурын биет хэмжээ 2011 онд 2005 оныхоос 65.0 хувиар буурсан хэдий ч 1 кг ноолуурын үнэ 18.7 дахин нэмэгдсэн байна.

Экспортын бараанд олборлох салбарын болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд, тухайлбал зэсийн баяжмал, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, цайрын баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, нүүрс, самнасан болон бохир ноолуур, боловсруулаагүй нефть зэрэг цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний эзлэх хувь өндөр хэвээр байна.

*Хүснэгт 4*

**Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, хувиар**

| | 2000 | 2005 | 2008 | 2009 | 2010 | 2011* |
|---|---|---|---|---|---|---|
| Эрдэс бүтээгдэхүүн (нефтийн бүтээгдэхүүн) | 19.6 | 27.7 | 29.7 | 26.7 | 23.6 | 19.2 |
| Машин, тоног төхөөрөмж | 21.7 | 21.7 | 18.7 | 19.8 | 21.3 | 27.2 |
| Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл | 10.9 | 9.9 | 14.1 | 12.7 | 19.0 | 22.9 |
| Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 7.7 | 6.7 | 7.1 | 8.3 | 7.5 | 5.0 |
| Бусад | 40.1 | 34.0 | 30.3 | 32.5 | 28.6 | 25.7 |

**- Урьдчилсан гүйцэтгэл*

Нийт импортод 2005-2011 онд машин, тоног төхөөрөмжийн бүлгийн эзлэх хувь 5.5 пункт, авто, агаар, усан замын тээврийн хэрэгслийн бүлгийнх 13.0 пунктээр нэмэгдэж, эрдэс бүтээгдэхүүний бүлгийнх 8.5 пункт, хүнсний бэлэн бүтээгдэхүүний бүлгийнх 1.7 пунктээр буурсан байна.

Импортын гол бүтээгдэхүүний нэг бол автобензин бөгөөд үнэ нь дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөс шууд хамааралтай байдаг. Автобензиний биет хэмжээ 2011 онд 2005 оныхоос 2.2 дахин, нэг тонн автобензиний үнэ 3.5 дахин өссөн байна. Манай улс нефтийн бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангадаг бөгөөд бараг 90 гаруй хувийг нь зөвхөн ОХУ-аас импортлож байна.

*Хүснэгт 5*

**Экспорт, импортын гол бүлгийн барааны биет хэмжээний индекс**

*2005=100*

| | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 |
|---|---|---|---|---|---|
| **Экспорт** | | | | | |
| Эрдэс бүтээгдэхүүн | 108.9 | 116.1 | 123.0 | 147.9 | 165.8 |
| Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 64.7 | 48.6 | 92.9 | 45.7 | 21.2 |
| Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 151.2 | 194.0 | 155.0 | 176.0 | 137.8 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 158.1 | 175.1 | 159.0 | 157.1 | 209.5 |
| **Импорт** | | | | | |
| Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 111.1 | 169.3 | 197.3 | 165.0 | 200.1 |
| Эрдэс бүтээгдэхүүн | 116.3 | 144.2 | 158.4 | 139.8 | 154.7 |
| Машин,тоног төхөөрөмж | 220.6 | 232.7 | 320.3 | 180.3 | 277.8 |
| Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл | 148.5 | 193.9 | 262.8 | 110.8 | 211.2 |

Экспортын дүнд өндөр хувь эзэлдэг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн биет хэмжээ 2005 оныхтой харьцуулахад нэмэгдсэн бол үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн биет хэмжээ буурсан байна. Харин импортын дүнд өндөр хувь эзэлдэг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, эрдэс бүтээгдэхүүн, машин,тоног төхөөрөмж, авто, агаар, усан замын тээврийн хэрэгслийн биет хэмжээ жил дараалан өссөөр байна.

Монгол улс 2000 онд 40 оронтой, 2005 онд 67 оронтой, 2009 онд 72 оронтой, 2010 онд нийт 67 оронтой, 2011 онд 65 оронтой экспортын худалдаа хийжээ. Экспорт 2000 онд 535.8 сая ам.доллар, 2005 онд 1063.9 сая ам.доллар, 2009 онд 1885.4 сая ам.доллар, 2010 онд 2908.5 сая ам.доллар, 2011 онд 4780.3 сая ам.долларт хүрч, 2000 оныхоос 9.8 дахин, 2005 оныхоос 5.0 дахин, 2009 оныхоос 2.8 дахин, 2010 оныхоос 1.9 дахин өссөн байна.

Экспортын голлох түнш орнуудтай хийсэн худалдааг авч үзэхэд 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспортын 92.1 хувь нь БНХАУ-д, 1.9 хувь нь Канад улсад, 2.0 хувь нь ОХУ-д, 0.2 хувь нь Япон улсад, 0.1 хувь нь АНУ-д, үлдсэн 3.7 хувь нь бусад улсад ногдож байна. Дээрх улсын экспортод эзлэх хувь 2000 оныхоос БНХАУ-ынх 40.9 пункт, Канад улсынх 1.8 пунктээр өсч, АНУ-ынх 24.4 пункт, ОХУ-ынх 6.4 пункт, Япон улсынх 1.3 пунктээр буурсан. 2005 оныхоос БНХАУ-ынх 43.9 пунктээр өсч, ОХУ-ынх 0.6 пункт, АНУ-ынх 14.2 пункт, Канад улсынх 9.6 пункт, Япон улсынх 0.3 пунктээр багаслаа. Харин 2010 оныхоос БНХАУ-ынх 7.3 пункт, Япон улсынх 0.1 пунктээр нэмэгдэж, Канад улсынх 3.0 пункт, ОХУ-ынх 0.8 пункт, АНУ-ынх 0.1 пунктээр буурлаа.

*Зураг 2.*




Дээрх зургаас харахад манай улсын экспорт, импортын 80 гаруй хувь нь цөөн хэдэн оронд ногдож байна. Экспортын дийлэнх нь БНХАУ-д ногдож байгаа нь манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, молибдений баяжмал, нүүрс, цайр зэргийг тус улсад экспортолдогтой холбоотой. Сүүлийн жилүүдэд манай улсын экспортын түнш орноор Канад улс тодорхой байр суурь эзлэх болсон нь боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтыг тус улсад тогтвортой нийлүүлэх болсон юм.

Манай улс 2000 онд нийт 61 улсаас, 2005 онд 89 улсаас, 2009 онд 109 улсаас, 2010 онд 127 улсаас, 2011 онд 124 улсаас бараа импортолсон байна. Импорт 2000 онд 614.5 сая ам.доллар, 2005 онд 1177.3 сая ам.доллар, 2009 онд 2137.7 сая ам.доллар, 2010 онд 3200.1 сая ам.доллар, 2011 онд 6526.9 сая ам.долларт хүрч, 2000 оныхоос 8.9 дахин, 2005 оныхоос 4.5 дахин, 2009 оныхоос 2.5 дахин, 2010 оныхоос 1.6 дахин нэмэгджээ.

Импортын худалдаанд голлох улсуудын эзлэх хувийг авч үзэхэд 2000 онд 33.6 хувийг ОХУ-тай, 20.5 хувийг БНХАУ-тай, 11.9 хувийг Япон улстай, 9.0 хувийг БНСУ-тай, 4.8 хувийг ХБНГУ-тай, 4.6 хувийг АНУ-тай хийсэн бол 2005 онд 35.5 хувийг ОХУ-тай, 25.8 хувийг БНХАУ-тай, 6.4 хувийг Япон улстай, 5.4 хувийг БНСУ-тай, 3.2 хувийг ХБНГУ-тай, 3.1 хувийг АНУ-тай, 2009 онд 36.2 хувийг ОХУ-тай, 25.2 хувийг БНХАУ-тай, 7.3 хувийг БНСУ-тай, 4.9 хувийг АНУ-тай, 4.5 хувийг Япон улстай, 3.3 хувийг ХБНГУ-тай, 2010 онд 32.7 хувийг ОХУ-тай, 30.3 хувийг БНХАУ-тай, 6.1 хувийг Япон улстай, 5.7 хувийг БНСУ-тай, 5.0 хувийг АНУ-тай, 2.7 хувийг ХБНГУ-тай, 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр импортын худалдааны 30.8 хувийг БНХАУ-тай, 24.5 хувийг ОХУ-тай, 8.2 хувийг АНУ-тай, 7.4 хувийг Япон улстай,
5.4 хувийг БНСУ-тай, 4.2 хувийг ХБНГУ-тай хийсэн байна.

*Зураг 3.*




Харин нийт импортын 30 орчим хувийг БНХАУ дангаараа эзэлж байгаа нь хүн амын өргөн хэрэглээний барааны дийлэнхийг энэ улсаас импортолж байгаатай холбоотой бөгөөд ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүний 90 гаруй хувийг импортолж, ОХУ манай улсын нийт импортын 20 гаруй хувийг эзэлж байна. Энэ нь манай улсын гадаад худалдаа хойд, урд хоёр хөрш орноос ихээхэн хамааралтай байгааг илтгэж байна.

**Дүгнэлт**

Манай улс далайд гарцгүй Төв Азийн зарим орнуудтай харьцуулахад экспортын барааны нэр төрөл цөөн юм. Энэхүү цөөн нэр төрлийн барааны экспорт нь гадаад худалдааны нийт эргэлт, улмаар эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж байгаа нь эдийн засгийн эмзэг байдлын нөхцлийг бүрдүүлсэн хэвээр байна.

Ази тивийн аж үйлдвэрийн салбар хурдацтай хөгжиж байгаатай холбоотойгоор зэс, цайр зэрэг эрдэс бүтээгдэхүүний эрэлт дэлхийн зах зээлд эрэлт жилээс жилд нэмэгдэж, цаашдаа ч энэ хандлага үргэлжлэхээр байгаа төдийгүй эрдэс бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд Ази тив тэр дундаа БНХАУ-ын эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн хандлагын үзүүлэх нөлөө ихэсч байна.

Уул, уурхайн зориулалттай хүнд машин, механизм, тоног, төхөөрөмжийн импорт өссөн. Мөн тээврийн хэрэгслийн импортын үнэ өссөн нь импортыг нэмэгдүүлж, гадаад худалдааны алдагдлын хэмжээг өсгөсөн.

Манай улс хүнсний өргөн хэрэглээний барааны дийлэнх хувийг импортоор хангаж байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймээс импортоор орж ирж буй бараа, бүтээгдэхүүний чанарт тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Цаашид, цөөхөн нэр төрлийн ашигт малтмал, түүхий эдийг гадаад зах зээлээс хамааралтай байдлаас гаргах, экспортын нэр төрлийн барааг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Манай улсын стратегийн гол бүтээгдэхүүн болох нефтийн бүтээгдэхүүнийг 100 хувь импортоор хангадаг болохоор дотоодын зах зээл дэх нефтийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнээс шууд хамаарч байна.

## Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

### Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

### АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 1 дүгээр сарын 27-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2011 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлынхаас 2.8 хувиар* өсчээ[1].

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхтай ижил түвшинд, өмнөх оны мөн үеийнхээс 3.0 хувиар өсчээ[2].

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 11 сард 512.8 тэрбум ам.долларын* алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 53.2 тэрбум ам.долл буюу 11.6 хувиар* өсчээ[3].

Тус улсын Холбооны нөөцийн сан (Төв банк)-гийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 хувиар өссөн байна[4].

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 1 дүгээр сард 8.3 хувь* болж, өмнөх сарынхаас 0.2 пунктээр буурчээ[2].

### Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтийн урьдчилсан тооцоогоор (2011 оны 12 дугаар сарын 9-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 1.4 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 5.6 хувиар өсчээ[5].

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 12 дугаар сард 99.4 (2010=100) байгаа нь өмнөх сарынхтай ижил түвшинд, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 хувиар буурчээ[6].

Гадаад худалдааны тэнцэл 2010 онд 6634.6 тэрбум иений ашигтай гарсан бол 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2496.0 тэрбум иений алдагдалтай гарчээ[7].

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 12 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 4.0 хувиар* өсч, өмнөх оны мөн үеийнхээс 4.1 хувиар буурчээ.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 12 дугаар сард 4.6 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пунктээр өссөн байна[9].

**ХАВСРАЛТ**

### Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны статистикийн байгууллагын урьдчилсан тооцоогоор (2011 оны 12 дугаар сарын 6-нд мэдээлснээр) тус холбооны гишүүн 27 орны зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.3 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 1.4 хувиар* өссөн байна.

Инфляцийн түвшин 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.0 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 11 сард 152.5 тэрбум еврогийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 5.1 тэрбум евро буюу 3.5 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.4 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 12 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 9.9 хувь* болж, өмнөх сарынхтай ижил түвшинд**, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 пунктээр өсчээ[9].

### ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор (2012 оны 2 дугаар сарын 2-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеийнхээс 4.9 хувиар өссөн байна[10].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 4.2 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 11 сард 178.8 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 42.7 тэрбум ам.долл буюу 31.4 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 2.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 12 дугаар сард 6.1 хувь болж, өмнөх сарынхаас 0.2 пунктээр буурчээ[11].

***** - Улирлын нөлөөллийг тооцсон***

*****- Европын холбооны Статистикийн байгууллагын 2012 оны 1 дүгээр сарын 31-нд мэдээлснээр***

## БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 1 дүгээр сарын 19-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 онд өмнөх оныхоос 9.2 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 4.1 хувиар өсчээ[12].

Гадаад худалдааны тэнцэл 2011 онд 155.1 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оныхоос 28.0 тэрбум ам.доллар буюу 15.3 хувиар буурчээ[13].

Харин аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 2011 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 12.8 хувиар өсчээ[12].

## Зэсийн үнэ

Лондонгийн металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 7567.55 ам.долл байсан бол 2012 оны 1 дүгээр сард дунджаар 8043.45 ам.долл болж, 475.90 ам.долл буюу 6.3 хувиар өссөн байна. 1 тонн цэвэр зэсийн үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 1512.25 ам.долл буюу 15.8 хувиар буурчээ[14] /Зураг 1/.

## Алтны үнэ

Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 1652.31 ам.долл байсан бол 2012 оны 1 дүгээр сард дунджаар 1656.12 ам.долл болж, 3.81 ам.долл буюу 0.2 хувиар өссөн байна. 1 унц алтны дундаж үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 299.72 ам.долл буюу 22.1 хувиар өсчээ15/Зураг 2/.

## Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррел газрын тосны үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 98.21 ам.долл байсан бол 2012 оны 1 дүгээр сард дунджаар 99.10 ам.долл болж, 0.89 ам.долл буюу 0.9 хувиар өссөн байна. 1 баррел газрын тосны дундаж үнэ 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 9.68 ам.долл буюу 10.8 хувиар өсчээ[16] /Зураг 3/.

## Хөрөнгийн биржийн индекс

АНУ-ын хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2012 оны 1 дүгээр сард дунджаар 12550.89 нэгж болж, өмнөх сарынхаас 475.21 нэгж буюу 3.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 748.52 нэгж буюу 6.3 хувиар нэмэгджээ[17].

Зураг-1




Зураг-2




Зураг-3



Токиогийн хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2012 оны 1 дүгээр сард дунджаар 8616.71 нэгж болж, өмнөх сарынхаас 109.38 нэгж буюу 1.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 1832.82 нэгж буюу 17.5 хувиар буурчээ[17].

Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2012 оны 1 дүгээр сард дунджаар 5694.45 нэгж болж, өмнөх сарынхаас 214.37 нэгж буюу 3.9 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 277.14 нэгж буюу 4.6 хувиар буурчээ[17].

**ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ИНДЕКС, сараар.**

нэгж

| Он | Аж үйлдвэрийн Dow Jones[1] | Nikkei-225[2] | FTSE-100[3] |
|---|---|---|---|
| 2011 I | 11802.37 | 10449.53 | 5971.59 |
| II | 12190.00 | 10622.27 | 6020.97 |
| III | 12081.48 | 9852.45 | 5856.92 |
| IV | 12434.88 | 9644.63 | 6007.86 |
| V | 12579.99 | 9650.78 | 5937.97 |
| VI | 12097.31 | 9541.53 | 5792.17 |
| VII | 12512.33 | 9996.68 | 5909.81 |
| VIII | 11326.62 | 9072.94 | 5271.31 |
| IX | 11175.45 | 8695.42 | 5228.49 |
| X | 11515.93 | 8733.56 | 5408.62 |
| XI | 11804.33 | 8506.11 | 5402.51 |
| XII | 12075.68 | 8507.32 | 5480.09 |
| 2011 I-XII | 11957.57 | 9429.30 | 5681.39 |
| 2012 I | 12550.89 | 8616.71 | 5694.45 |

*Тайлбар:*

1. *АНУ-ын хөрөнгийн биржийн индекс*
2. *Токиогийн хөрөнгийн биржийн индекс*
3. *Лондонгийн хөрөнгийн биржийн индекс*

***Эх үүсвэр:***


1. *http://bea.gov*
2. *http://stats.bls.gov*
3. *http://www.census.gov/foreign-trade*
4. *http://www.federalreserve.gov*
5. *http://www.esri.cao.go.jp*
6. *http://www.stat.go.jp*
7. *http://www.customs.go.jp*
8. *http://www.meti.go.jp*
9. *http://epp.eurostat.ec.europa.eu*
10. *http://www.economy.gov.ru*
11. *http://www.gks.ru*
12. *http://www.stats.gov.cn*
13. *http://www.mofcom.gov.cn*
14. *http://www.lme.com*
15. *http://www.lbma.org.uk*
16. *http://www.nymex.com*
17. *http://finance.yahoo.com*

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд хэвлэв.

Хаяг :
Засгийн Газрын III байр, Өрөө-113
Улаанбаатар - 20а, Монгол Улс
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn,
nso@magicnet.mn
Факс: (976-11) 324518
Утас: 322424, 326414